



211

**БАГАНУУР ДҮҮРГИЙН  
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 12 сарын 28 өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

Стратеги төлөвлөгөө батлах тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2015 оны 122 дугаар тогтоолоор батлагдсан Багануур Үйлдвэрлэл Технологийн Парк ОНӨТҮГ-ын дүрмийн 5.1.8, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Өмчийн харилцааны газрын даргатай 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр байгуулсан Конрактын 3.26 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын тогтвортой хөгжил, найдвартай ажиллагааг хангах, байгальд ээлтэй шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зорилгоор хөгжлийн үзэл баримтлалыг тусгасан Паркийн хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Паркийн хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Үйлдвэрлэл, технологийн алба /Д.Алтангэрэл/-нд даалгасугай.

3. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж байхыг Нягтлан бодогч /Л Оюунцэцэг/-д даалгасугай.


ДАРГА



Ч ЭЛБЭГСАЙХАН



**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК”**  
**ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН**  
**СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**  
**/2017-2020 ОН/**



Улаанбаатар 2017 он

## **БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ийн СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2017-2020) БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ**

### **Стратеги удирдлагын багийн зорилго:**

“БҮТП” ОНӨТҮГ-ын тогтвортой хөгжил, найдвартай үйлажиллагааг хангах, байгальд ээлтэй шинэ дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх зорилгоор хөгжлийн үзэл баримтлал боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг гаргахад оршино.

### **Хөгжлийн баримт бичгийг боловсруулах ажлын хүрээнд:**

- Нөхцөл байдлын иж бүрэн шинжилгээ хийх
- “БҮТП” ОНӨТҮГ-ын хөгжлийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйл, үндсэн чиглэлүүдийг тодорхойлох
- Байгууллагын хөгжлийн зорилтуудын хувилбаруудыг гаргаж ирэх
- 2017-2020 оны стратеги төлөвлөгөөний төсөл боловсруулах
- Бичиг баримтуудын төслийг хэлэлцүүлж санал авах
- Бичиг баримтын төслийг эцсийн хувилбараар боловсруулж батлах.

### **Хүлээгдэж буй үр дүн:**

- Гадаадын хөрөнгө оруулалттай төсөл хөтөлбөрүүд хэрэгжих үндэс суурь бий болно.
- Төслийн тусламжтайгаар байгуулагдах үйлдвэрүүд ашиглалтанд орсноор Нийслэл хотын дагуул хот болох Багануурт байнгын ажлын байр бий болж, хэт төвлөрөл саарна.
- Стратегийн хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын бүтэц, үндсэн нэгж хэсгүүдийн чиг үүргийг тодорхой болгоно.
- Стратеги төлөвлөгөөний үйл явц, гүйцэтгэлийг үнэлэх, хянах шалгуурууд тодорхой болно.
- Дээрх бичиг баримтыг үндэслэн жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд стратегийн зорилтуудыг нарийвчлан тусгаж хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

## **АГУУЛГА**

<b>УДИРТГАЛ</b>	3
<b>СУДАЛГААНЫ ТОВЧ ХУРААНГУЙ</b>	4
<b>НЭГ.ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ</b>	8
<b>ХОЁР. БАГАНУУР ҮЙЛДВЭР ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ</b>	19
<b>ГУРАВ.НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ</b>	31
<b>ДӨРӨВ. УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ СОНГОЛТ, БОЛОМЖИТ ХУВИЛБАР</b>	33
<b>ТАВ. ГОЛ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ</b>	34
<b>ЗУРГАА. “CROSS, SWOT” ШИНЖИЛГЭЭ</b>	36
<b>ДОЛОО. “БҮТГ” ОНӨТҮГ-ЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛС</b>	38
<b>НАЙМ. ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ХӨГЖЛИЙН ҮНДСЭН ЗОРИЛГУУД</b>	39
<b>ЕС. ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД</b>	40
<b>АРАВ.СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ</b>	43
<b>АРВАН НЭГ. СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЯВЦАД АШИГЛАГДАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨРӨЛ ЧИГЛЭЛҮҮД</b>	70
<b>АРВАН ХОЁР.ЭРХЭМ ЗОРИЛГО ЗОРИЛТУУД, СТРАТЕГИУДИЙН ЛОГИК ХОЛБОО</b>	71
<b>АРВАН ГУРАВ.СТРАТЕГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ</b>	73
<b>АРВАН ДӨРӨВ.СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮТЭЦ</b>	74

## УДИРТГАЛ

“БҮТП” ОНӨТҮГ-ын өнөөгийн нөхцөл байдалд хийсэн судалгаа шинжилгээ, бодлогын баримт бичгүүдэд үндэслэн тус байгууллагын стратеги төлөвлөгөөний төслийг боловсрууллаа. Тус төлөвлөгөөнд тус паркийн давуу талуудыг бататгахын хамт боломжуудыг ашиглах, сул талуудыг бууруулах замаар өрсөлдөх чадвараа дээшлүүлэх ба тулгарч болзошгүй эрсдэлийг даван туулахад чиглэсэн үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх алхмуудыг тодорхойлсон болно. Стратеги төлөвлөгөө боловсруулах хугацаанд тус паркийн үйл ажиллагаанд нөхцөл байдлын шинжилгээг дараах аргуудаар хийж шаардлагатай мэдээллийг цуглуулан боловсруулалт хийсэн болно. Үүнд:

1. Паркийн үйл ажиллагаанд нөлөөлөх гадаад орчны шинжилгээ
  - a. Улс төрийн орчин(макро)
  - b. Эрх зүйн орчин(макро)
  - c. Эдийн засгийн орчин(макро)
  - d. Хүн ам зүйн орчин(макро)
  - e. Байгаль экологийн орчин(макро)
  - f. Технологийн хөгжлийн орчин(макро)
  - g. Хэрэглэгчийн орчин(микро)
2. Паркийн ажлын гүйцэтгэл үр дүнг харуулсан бичиг баримтанд хийсэн шинжилгээ
  - a. “БҮТП” ОНӨТҮГ-ын тайлан
  - b. Санхүүгийн аудитын тайлан
3. Паркийн удирдах ажилтан болон үндсэн мэргэжлийн хэлтэс, албадуудыг хамарсан уулзалт ярилцлага, шинжилгээний үр дүн
  - a. Удирдлагууд
  - b. Ажилтнууд
4. Ажлын байрны зураг авалт
  - a. Үндсэн үйл ажиллагаа
  - b. Бүрдүүлэгч ажилбар
  - c. Тулгамдсан асуудал
  - d. Шийдвэрлэх боломж
5. Паркийн инженер, техникийн ажилтнууд, нэгжийн мэргэжилтнүүдээс авсан санал асуулга зэрэг болно.

Эдгээр судалгааг үндэслэн стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулж 2017-2020 оны үйл ажиллагааны үндсэн чиглэлүүд болон зорилтуудыг тодорхойлон гаргаж улмаар түүнийг хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг урьдчилсан байдлаар боловсрууллаа. Стратеги төлөвлөгөөний төсөл боловсруулах явцад Монгол орны нийгэм эдийн засгийн байдал, улс төрийн сонгуулийн үйл ажиллагаа зэрэг нь хүчтэй нөлөө үзүүлж байлаа.

Судалгааны ажлын ерөнхий үр дүнгээс харахад эдийн засгийн эрчимжилт буурч, томоохон төсөл хөтөлбөрүүд зогсонги байдалд орсон нь гадаад орчинд чиглэсэн идэвхтэй төлөв байдлаас илүүтэй дотоод үйл ажиллагаандаа түлхүү анхаарах, эрсдлийг бууруулах, зардлыг оновчлох замаар өрсөлдөх чадварыг сайжруулах шаардлагатай гэх ерөнхий үр дүн ажиглагдаж байна.

Улс орноос хэрэгжүүлж буй барилгажуулах үйл явц, нийслэл хотын болон Багануур дүүргийн ерөнхий төлөвлөгөө, гэр хорооллын дахин төлөвлөлт зэрэг нь ирээдүйд тус байгууллагын үйл ажиллагаанд ихээхэн өөрчлөлт оруулах нь дамжиггүй юм. Урт болон дунд хугацааны төлөвлөгөөний зорилго, зорилтууд ба үнэт зүйл, үзэл баримтлалууд нь удирдлагаас баримтлаж буй ирээдүйн төсөөлөлтэй уялдсан бөгөөд тус паркийн ажилтан, ажилчдын зүгээс үнэтэй санал зөвлөмж өгснийг тэмдэглэх нь зүйтэй.

## **СУДАЛГААНЫ ТОВЧ ХУРААНГУЙ**

“БҮТП” ОНӨТҮГ-ын 2017-2020 оны дунд хугацааны стратегийн төлөвлөгөөг “БҮТП” ОНӨТҮГ-ын захиалгаар холбогдох эрдэмтэн судлаачдын шууд оролцоо зөвлөгөөгөөр “БҮТП” ОНӨТҮГ-ын ажлын хэсэг гүйцэтгэв.

### **1. Паркийн үйл ажиллагаанд нөлөөлөх гадаад орчны шинжилгээ**

#### **а) Эрх зүйн орчин (макро)**

Энэ судалгаа нь Монгол Улсын үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа нь дараах эрх зүйн акт хууль тогтоомжуудын хүрээнд зохицуулагдаж, түүний үндсэн зорилтууд хэрэгжих үндсэн нөхцөл бүрдсэн болно. Үүнд:

- Үндсэн хууль
- Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, 2015 он
- Хөрөнгө оруулалтын тухай хууль, 2013 он
- Инновацийн тухай хууль, 2012 он
- Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, 2009 он
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, 2008 он
- Хот байгуулалтын тухай хууль, 2008 он
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, шинэчилсэн найруулга, 2006 он
- Газрын тухай хууль, 2002 он
- Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хууль, 2000 он үгдсэн
- Газрын төлбөрийн тухай хууль, 1997 он
- УИХ-ын 2008 оны 12-р тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” /2007-2021 он/
- УИХ-ын 2003 оны 54-р тогтоолоор батлагдсан “ҮТП байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл”
- Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 104 тоот тогтоол “Журам чиглэл батлах тухай” (Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих тухай)
- Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал
- Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө
- Нийслэлийн бүсийн хөгжлийн цогц бодлого (2009-2021 он)
- Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 247 тоот тогтоол
- Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 168-р тоот тогтоол “Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай”

2009 онд батлагдсан Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулиар тус байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл хүрээ

тодорхой болсон бөгөөд бие даасан ажил үйлчилгээ явуулах боломж бүрдсэн болно.

Монгол Улсын Засгийн Газраас үйлдвэржилтэд суурилсан хөгжлийн бодлогоо тодорхойлж, түүний дагуу үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах нь тэргүүлэх зорилго байсаар ирсэн.

Монгол Улсыг Үйлдвэржүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд аж үйлдвэрийн парк цогцолборуудыг байгуулахад чиглэсэн бодлогын баримт бичгүүд гарч “Багануур Үйлдвэрлэл, Технологийн Парк” Орон Нутгийн Өмчит Төсөвт Үйлдвэрийн Газар байгуулагдсан.

Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 272 дугаар тогтоолоор тус Газарт Паркийн үйл ажиллагаа эрхлэх 2016/01 тоот тусгай зөвшөөрөл олгож, Нийслэлийн Засаг даргын 2016 оны 06-р сарын 02-ны өдрийн А/447 тоот захирамжаар Паркад олгогдсон 403.3 га /5 байршилд/ газар эзэмшүүлэх шийдвэрийг үндэслэн газар эзэмших эрхийг гэрчилгээгээр баталгаажуулсан.

Стратегийн энэхүү бичиг баримтын хүрээнд “БҮТП” ОНӨТҮГ-ын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг сайжруулах тодорхой саналуудыг дэвшүүлэн тавьсан болно. Хэрэв эдгээр гаргасан санал, дүгнэлтүүдийг Монгол Улсын Засгийн газар, Нийслэл хотын болон Багануур дүүргийн хөгжлийн бодлого болгон хэрэгжсэнээр зүүн бүс нутагт үйлдвэржилт шинээр бий болж Нийслэлийн хүн амын хэт төвлөржилт саармагжиж, ажлын байр олноор бий болж иргэдийн амьдралын чанар дээшлэх угтвар нөхцөл бүрдэнэ.

#### б) Улс төрийн орчин(макро)

2003 оноос хойш Монгол улсын томоохон хотуудыг түшиглэн үйлдвэрлэл, технологийн парк, шинжлэх ухааны парк, аж үйлдвэрийн парк зэргийг байгуулж хөгжүүлэх хууль, эрх зүйн баримт бичгүүд /дээр дурдсан/ гарсан боловч өнөөг хүртэл сонгодог утгаар үйлдвэр технологийн парк баригдаж чадаагүй нь дараах нийтлэг бэрхшээл саадууд байсантай холбоотой. Үүнд:

1. Төрийн бодлогын залгамж халаа алдагдсан. Нэг Засгийн газрын шийдвэрийг дараагийн Засгийн газар өөрчилдөг.
2. Үе үеийн Засгийн газрын хугацаанд ҮТ Паркийн асуудал тогтвортой нэг дээд удирдлагад харъяалагдаж байгаагүй. Паркийн асуудал ҮХЯ, ХХААХҮЯ, АҮЯ, УУХҮЯ- зэрэг Яамдуудын дунд шидэгдэж, Газар, хэлтсүүд нь талцаж, гүйцэтгэх үүрэг, хариуцлага нь сарнисантай холбоотой.
3. Яамдууд өөр өөрийн үйл ажилагааны чиглэлээр паркууд байгуулах Засгийн газрын шийдвэр гаргуулсан. Жишээ нь: ХХААХҮЯ үйлдвэрлэл, технологийн парк, БСЖУЯ шинжлэх ухааны парк, АҮЯ аж үйлдвэрийн парк, УУХҮЯ уул уурхайн том үйлдвэр түшиглэсэн парк гэх мэт. Гэтэл Засгийн газар нь ижил тэгш эрхтэй Яамдуудаас аль нэг Яаманд Паркийн асуудлыг хариуцуулахад үйл ажиллагаа үр дүнд хүрэхгүй байна.

*Дээрх саад тотгорыг давж гарах оновчтой гарц шийдэл нь эрхэлсэн шадар сайдын чиг үүрэгт хамааруулж, төвлөрүүлэх явдал юм.*

Багануур Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах талаар урьд өмнө гарсан тодорхой шийдвэр түүний зарим үр дүнг товч дурьдвал:

- Анх 2003 онд УИХ-ын "Үйлдвэрлэл Технологийн Парк /ҮТП/ байгуулах үндсэн чиглэлүүдийг тогтоох тухай" хууль гарсан. Уг чиглэлд Багануурт парк байгуулах тухай тусгагдаагүй.
- 2008 онд ҮХЯ-ны шийдвэрээр Эрдэнэт, Дархан, Налайх г.м болон Багануурт ҮТП байгуулах ТЭЗҮ боловсруулах үүрэг Засгийн газрын харъяа Эдийн засгийн хүрээлэнд үүрэг өгөгдөж Багануур ХК, Монхимо компаниуд төсөл боловсруулахад хамтран оролцсон. Багануурын Үйлдвэрлэл, технологийн паркийн анхны ТЭЗҮ тэр үед батлагдсан.
- Улмаар 2009 онд УИХ-ын ҮТП-ийн эрх зүйн байдлын тухай хууль гарч, парк байгуулах үйл явц эхлэх нөхцөл бүрдсэн.
- Уг хуулиар улсын томоохон компаниудад парк байгуулах эрх олгогдсоны дагуу Багануур ХК Багануур дүүрэгт парк байгуулах тусгай зөвшөөрлийг 2012 онд авч паркийн удирдлагыг тэргүүн дэд захирлаар удирдуулан томилж, парк хариуцсан мэргэжилтний орон тоог баталж ажиллуулсан байна. Тус компани нь өөрийн хөрөнгөөр "Багануурын Үйлдвэрлэл, Технологийн Парк" нэртэй хараат компани байгуулахаар бэлтгэж байсан ч Нийслэл нь паркийн газрын зөвшөөрөл олгох, Яам нь паркийн үйл ажиллагаа эрхлэх гэрээ байгуулах асуудлыг 3 жил хойшлуулсан байна.
- Дүүргийн Засаг даргын санаачлагаар паркийн удирдлага, үйл ажиллагааг дүүрэгт шилжүүлэх асуудлыг 2015 онд АҮЯам, Нийслэлийн ЗДТГ-т тавьснаар Багануур ХК парк байгуулах өөрийн тусгай зөвшөөрлийг цуцлуулсан.
- Нийслэлийн ИТХ-ын 2015 оны 7дугаар сарын 3-ны өдрийн 122 дугаар тогтоолоор "Багануур Үйлдвэрлэл, Технологийн Парк" Орон Нутгийн Өмчит Төсөвт Үйлдвэрийн Газар байгуулах ажил дөнгөж эхэлсэн түүхтэй.

в) Эдийн засгийн орчин(макро)

Паркийг эрчимтэй хөгжүүлж эрчимжүүлэхэд дараах нөхцөл байдлууд онцгой нөлөөлж байна. Үүнд:

**1. Нийслэл хотын өнөөгийн байдал.**

- Нийслэл хотын агаар, хөрс, усны болон ургамал, амьтны амьдрах орчны бохирдол туйлдаа хүрч байгаль экологийн тэнцвэрт байдал алдагдсан.
- Хүн амын тоо 1.440 саяд хүрч хэт төвлөрөл үүссэн нь нийгэм, эдийн засагт сөрөг үр дагаврыг авчирч байна.
- Үйлдвэрүүдийн хэт бөөгнөрөл болсон нь орчны бохирдлыг нэмэгдүүлэв.
- Хорт хаягдал үүсгэдэг арьс шир, төмөрлөгийн гэх мэтийн жижиг үйлдвэрүүд ажилласаар байна.

Засгийн Газрын 2017оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 98 дугаар тогтоолоор батлагдсан "Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх үүднээс нийслэлээс бохирдол үүсгэгч үйлдвэрүүдийг гадагшлуулах, хүн амын хэт төвлөрлийг саармагжуулах арга хэмжээг эрчимтэй зохион байгуулах замаар дагуул хотуудын үйлдвэрлэл технологийн паркийг хөрөнгө оруулалтаар дэмжих шаардлага гарч ирсэн.Энэхүү нөхцөл байдлыг



зөвөөр ашиглах нь паркийн үйлдвэржилтийг урагшлуулахад эерэг нөлөө үзүүлнэ.

## **2. Багануурын уурхайн хэтийн төлөв байдал**

Уурхайн нөөц хэдийгээр 800,0 гаруй сая тонн байгаа ч одоо баригдаж байгаа цахилгаан станц, төлөвлөгдөж байгаа нүүрсний шингэн түлшний болон боловсруулах үйлдвэрүүдийн өсөн нэмэгдэх хэрэгцээг нүүрсээр хангаж ажиллахад 45-50 жилийн дараа уурхай хаагдах горимд орно. Иймд багахан нутаг дэвсгэр дээр нь байгалийн өөр их нөөц байхгүй болоход Багануур хотын хүн ам юунд түшиглэж амьдрах вэ? гэдэг асуудлын хариуг гагцхүү Үйлдвэрлэл, технологийн паркийн бодлого, хөгжилтэй шууд холбохоос аргагүй.

Мөн уурхайн мэргэжилтэй боловсон хүчнийг цаашид ажлаар хангах, улс орны хэтийн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулах нарийн төвөгтэй зорилтууд ч цаашид урган гарч ирнэ гэдгийг энд харгалзан үзэх учиртай.

Манай орны төвийн эрчим хүчний үйлдвэрлэлд нүүрсний хомсдол үүсч 1960 оноос Зөвлөлт холбоот улс болон Чех, Герман зэрэг орнуудтай хамтарсан хайгуулын ажил төвийн бүс нутгуудад эрчимтэй хийж эхэлснээр 1973 онд 599,8 сая тонн хүрэн нүүрсний нөөцийг Нүүрэнтийн хөндийд илрүүлсэнтэй холбогдож Багануур дүүрэг нь 1980 оны 02 сарын 14-ны өдөр Ардын Их хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор нийслэл хотыг нүүрсээр хангах суурин газар болж байгуулагдсан.

**Нийслэл Улаанбаатар хотоос -135 км зайтай.**

**Засаг захиргааны нэгж - Багануур дүүрэг 5 хороотой.**

**Газар нутаг - 62,2 мянган га**

**Хүн ам - 27440(2017оны байдлаар)**

**Хөдөлмөрийн насны хүн ам - 17,000 орчим**

**Ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо - 987**

**Малын тоо: 149123**

Эрчим хүч, дулаан, усан хангамжийн найдвартай эх үүсвэртэй, өндөр хурдны шилэн кабелиуд, цахилгаан холбоо үүрэн холбооны сүлжээнд бүрэн холбогдсон.инженерийн болон нийгмийн дэд бүтцийн хөгжил сайтай зэрэг олон давуу талуудтай.Үүнд:

- Багануур дүүргийн нутаг дэвсгэрт байх 95 км урттай төмөр зам, Ази, Европ тивийг холбосон төмөр замтай шууд холбогддог.
- Монгол орны баруун, зүүн хязгаарыг холбосон хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто зам тус дүүргийн нутаг дэвсгэрийг дайран өнгөрдөг.
- Төвийн эрчим хүчний системд Улаанбаатар дэд станцаас 220кВ цахилгаан дамжуулах 2 хэлхээт агаарын шугамаар холбогддог
- Багануур 220/110/35кВ дэд станц, 110/6кВ Хот, Төв, Галуут дэд станцаар цахилгаан эрчим хүчийг дамжуулдаг
- 200гкал дулаан үйлдвэрлэх хүчин чадалтай дулааны станц ажиллаж байна.
- Миком, Мобинет,Скаймедиа, Юнивишн, Рэйлкомын өндөр хурдны шилэн кабелиудад холбогдсон.
- Цахилгаан холбоо компанийн 7021 дугаарлалттай тоон системийн суурин утасны сүлжээтэй бөгөөд Мобиком, Юнител, Скайтел, Жи мобайлын үүрэн холбооны сүлжээнд бүрэн холбогдсон.

Тус бүс нутагт нүүрс,уурхайн овоолог шороо, мал аж ахуй, байгалийн гаралтай түүхий эдийг бүрэн боловсруулж, өндөр технологид тулгуурласан үйлдвэрлэлийг хөгжүүлэн экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн дотоод, гадаад зах зээлд гаргах боломжтой.

## **АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, 2015 ОНЫ БАЙДЛААР** **/жилд/**

• Нүүрс олборлолт	3252.4 тонн
• Дулаан дамжуулалт	135.1 Гкал
• Талх үйлдвэрлэлт	110.6 тонн
• Нарийн боов үйлдвэрлэлт	140.9 тонн
• Арматур үйлдвэрлэлт	8100.0 тонн

Тус дүүргийн эдийн засгийн гол салбар нь нүүрс олборлолт бөгөөд 2014-2015 онд Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар “Багануур” ХК-д Багануурын нүүрсний ордын хайгуулын ажил хийгдсэн. Хайгуулын үр дүнд балансын нөөц 280.0 сая.тн-оор нэмэгдэж Олон улсын JORC стандартаар үнэлэгдсэн нийт 812.0 сая.тн баталгаат нүүрсний нөөцтэй гэж тогтоогдсон. Багануурын уурхай нь жилд 3,0-3,5 сая тонн хүрэн нүүрс олборлож, Монгол улсын нүүрсний хэрэгцээний 60 хувь, Төвийн бүсийн эрчим хүчний хэрэглээний 70 орчим хувийг хангаж байна.

Хотын нийт аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 90.0%-ийг зөвхөн нүүрс олборлолт, 6.3%-ийг цахилгаан, 3.4%-ийг дулаан, 0.2%-ийг хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл эзэлж байгаа нь салбарын бүтцийг цаашид боловсронгуй болгох шаардлагатайг харуулна.

“Багануур” ХК-ийн судалгаа хөгжлийн төвийн санаачлагаар “Багануурын нүүрс хими-хийн үйлдвэрлэл технологийн парк” байгуулах тусгай зөвшөөрлийг Аж үйлдвэрийн яамнаас ХХААХҮЯ-наас 2012.05.23-ны өдөр авсан ч газар болон нэгжүүдтэй гэрээ байгуулаагүй 2015 он хүрсэн байдаг. 2015 оноос Багануур дүүргийн захиргаа санаачлага гарган Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд санал тавьснаар НИТТХ-ын 2015.07.03-ны өдрийн 122 дугаар тогтоолоор “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг /цаашид ОНӨТҮГ гэх/ байгуулж дүүрэгт 2016 оны 01-р сарын 01-нээс эхлэн нийслэлийн төсвөөс санхүүжиж, бүтэц орон тооны дагуу үйл ажиллагаагаа эхэлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2016 оны 06-р сарын 02-ны өдрийн А/447 тоот захирамжаар Паркад олгогдсон 403.3 га /5 байршилд/ газар эзэмшүүлэх шийдвэрийг үндэслэн газар эзэмших эрхийг гэрчилгээгээр баталгаажуулсан

Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 272 дугаар тогтоолоор Паркийн үйл ажиллагаа эрхлэх 2016/01 тоот тусгай зөвшөөрөл олгогдсон

ҮХААЯ-ны захиалгаар ШУТИС, “Мэргэшсэн инженерүүдийн нийгэмлэг ТББ” хамтран Багануур Үйлдвэрлэл, Технологийн Паркийн нарийвчилсан техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан. Үүнээс гадна 2017 оны 11-р сарын 25-нд Багануур ҮТП-ийн гаргасан хүсэлтийн дагуу БХБЯ-наас хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээ дэд бүтцийн зураг төслийн Зөвлөх үйлчилгээний тендер зарлагдан одоо сонгон шалгаруулалт хийгдэж байна.

### **Багануур хотын өнөөгийн байдал**

Багануур хот нь цахилгаан, дулааны эрчим хүч, усан хангамжийн найдвартай эх үүсвэртэй, инженерийн болон нийгмийн дэд бүтцийн хөгжил сайтай, иргэдийн амьдрал, ахуйн соёлын түвшин харьцангуй сайн зэрэг бусад орон нутгийн хотуудтай харьцуулахад онцлох шинж чанаруудтай.

*Газар нутгийн байршил.* Багануур дүүрэг нь 62,2 мянган га нутаг дэвсгэртэй бөгөөд үүний 41,6 мянган га нь ХАА-н, 19,3 мянган га нь хот суурины, 4,71 га нь зам, шугам сүлжээний, 14,26 га нь улсын тусгай хэрэгцээний, бусдыг нь ойн болон усны сан эзэлдэг. Үйлдвэрлэл хөгжүүлэх зорилгоор ашиглаж болохуйц эдэлбэр газар байгаа нь паркийг хөгжүүлэх нэг таатай нөхцөл юм.

#### **Хотжилт ба ажиллах хүчний нөөц.**

2017 оны байдлаар Засаг захиргааны 5 хороо, 7824 өрхийн 27440 хүн оршин сууж байгаагаас хөдөлмөрийн насны 16 мянга орчим хүн амьдарч байна. Дүүрэгт баклавар мэргэжилтэй 233, бүрэн дунд боловсролтой, мэргэжилтэй 458, тусгай дунд боловсролтой, мэргэжилтэй 67 хүн ажиллаж амьдарч байна. Одоогоор томоохон их дээд сургуулийн салбар байхгүй. Мэргэжилтэй ажилчдыг бэлтгэдэг “Гэрэлт–Ирээдүй” мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвтэй. Дүүргийн “Гэрэлт ирээдүй” МСҮТ нь 2014 онд мэргэжил эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч мэргэжил олгох сургалтыг зохион байгуулж байна. Төв нь 4 мэргэжлийн дадлагын байртай бөгөөд 2017-2018 онд хичээлийн төв байр, 2018-2019 онд дотуур байрыг ашиглалтанд оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Тус төв нь 1 ба 2,5 жилийн хугацаагаар түгээмэл мэргэжлийн сургалтыг зохион байгуулдаг. Нэг жилийн ангид бүрэн дунд боловсролтой, нас харгалзалгүйгээр хүмүүсийг хамруулж үйлдвэрийн цахилгаанчин, гагнуурчин, барилгын сантехникч, бетон арматурчин, өрөгч угсрагч, засал-чимэглэлч, сүлжмэлийн үйлдвэрийн технологийн /сүлжигч/ ажилчин, хуванцар цонх, хаалганы үйлдвэрийн ажилчин зэрэг мэргэжил эзэмшүүлж байна.

Мөн 2,5 жилийн ангид бүрэн бус дунд боловсролын гэрчилгээтэй 9-р анги төгссөн суралцагчдыг элсүүлж, үйлдвэрийн цахилгаанчин, гагнуурчин, барилгын сантехникч, бетон арматурчин, өрөгч угсрагч, засал-чимэглэлч зэрэг мэргэжил эзэмшүүлэхийн зэрэгцээ бүрэн дунд боловсрол олгож төгсгөдөг байна.

Цаашдаа тус МСҮТ-ийн сургалтын мэргэжлийн төрөл нь түгээмэл шинжтэй бөгөөд паркт шинээр байгуулагдах үйлдвэрүүдийн нарийн мэргэжилтэй тохирохгүй, багш нарын эзэмшсэн мэргэжил нь үйлдвэрүүдийн нарийн мэргэжилд нийцэхгүй байгааг харгалзаж, Төвийн материаллаг баазыг өргөтгөж бэхжүүлэх, дотоод зохион байгуулалт, сургалтын программыг шинэчлэн хөгжүүлэх, нэг талаар хөрөнгө оруулагч компаниудтай хамтрах замаар ямар ч өндөр технологийн шинэ үйлдвэрийн нарийн мэргэжлийн


сургалтыг зохион байгуулах боломжтой байхаар өөрчлөн шинэчлэх шаардлагатай юм.

Паркийн үйл ажиллагааны үр дүнг тодорхойлох нэг үзүүлэлт нь үйлдвэрүүд баригдаж хичнээн ажлын байр шинээр бий болж, дүүргийн ажилгүйдлын тоо хэдээр буурав гэдэгт байх учир ажилгүйдлын талаар судалгаа явуулав.

**Багануур дүүргийн хөдөлмөрийн зах зээлийн 1 дүгээр сарын статистик мэдээ**

<b>Ажил хайгч иргэн</b>	<b>634</b>
• Эмэгтэй	328
• Эрэгтэй	306
<b>Ажлын байрны захиалга</b>	<b>62</b>
<b>Ажилд зуучлагдан орсон</b>	<b>50</b>
• Эмэгтэй	23
• Эрэгтэй	27
<b>Шинэ ажлын байр</b>	<b>4</b>

**Зураг 1. Бүртгэлтэй ажил хайгч иргэн (насны ангилалаар)**



Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт явуулахад дүүргийн мэргэжлийн байгуулагатай нягт хамтран ажиллах шаардлага гарна.

Дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс нь өөрийн нутаг дэвсгэрт Монгол улсын хууль тогтоомж, стандарт, дүрэм журмын хэрэгжилтэд Төрийн захиргааны хяналт тавих замаар иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах,

чанартай ажил үйлчилгээг хүргэх, хөдөлмөрлөх эрхийг хангах, бизнес эрхлэгчдийн таатай орчинг бүрдүүлэх чиг үүргийн хүрээнд байгаль орчин, барилгын техник, хүнсний чанар, стандарт, эрүүл ахуй халдвар хамгаалал, хөдөлмөрийн эрүүл ахуй, мал эмнэлэг, хөдөлмөрийн болон боловсролын хяналтыг тавьж байна.

Хяналтын Лабораторт Монгол улсын үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болсон хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, хүнсний аюулгүй байдлыг хангах, хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бараа бүтээгдэхүүн хэрэглэх нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн бие даасан хараат бус магадлан шинжилгээний дүнгээр баталгаажуулах үйл ажиллагааг гүйцэтгэдэг байна.

### **Үйлдвэржилт**

Багануур дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй томоохон үйлдвэр, ААН байгууллагын хувьд "Багануур" ХК /нүүрс/, Мон цахим ХХК/ өндөр чадлын цахилгаан хөдөлгүүрийн засвар/, Монхимо ХХК /нано технологид суурилсан эмийн болон гоо сайханы бүтээгдэхүүн үйлдвэрлэл/, Багануур цахилгаан механикийн үйлдвэр ХХК /өндөр ба нам хүчдэлийн подстанц болон хуваарилах байгууламж тоноглолын үйлдвэрлэл, БЗӨБЦДС ТӨХК, Дулааны станц ТӨХК /дулааны эрчим хүч үйлдвэрлэл/, Багануур Ус ОНӨААТҮГ /ус хангамж/, Төмөрлөгийн үйлдвэр/ хаягдал төмөр боловсруулах үйлдвэр/, Хөх дөрвөлжин ХХК / модны үйлдвэр/, Жоншны үйлдвэр, Дайрганы үйлдвэр болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид байна.

#### **Хүснэгт 1. Багануур хотод үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо**

№	Үйл ажиллагааны чиглэл	Аж ахуйн нэгжийн тоо	Эзлэх хувь
1.	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй	8	3.1
2.	Уул уурхай, олборлох үйлдвэр	2	0.8
3.	Боловсруулах үйлдвэр	23	8.8
4.	Цахилгаан, дулаан, эрчим хүч	5	1.9
5.	Барилга	10	3.8
6.	Худалдаа	66	25.4
7.	Зочид буудал, зоогийн газар	11	4.2
8.	Тээвэр, агуулах, холбоо	4	1.5
9.	Санхүүгийн үйлчилгээ	45	17.3
10.	Үл хөдлөх хөрөнгө, түрээс бизнес	13	5.0
11.	Төрийн удирдлага, батлан хамгаалах, даатгал	12	4.6
12.	Эрүүл мэнд, нийгмийн халамж	18	6.9
13.	Боловсрол	14	5.4
14.	Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	29	11.2
Нийт		<b>260</b>	<b>100.0</b>

Үйлдвэржилтийн өнөөгийн байдлыг харахад дараах дүр зураг байна.

- Нүүрсний уурхайгаас өөр томоохон үйлдвэр үгүй
- Жижиг дунд үйлдвэр сул хөгжсөн
- Эмэгтэйчүүдийн ажлын байр хомс
- Ажилгүйдэл ихтэй

- Улаанбаатар хотоос алслагдсан байршилтай
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл хөгжөөгүй
- Барилгын салбар зогсонги байдалтай.
- Дүүргийн хүн амын хүнсний хангамжийн өргөн хэрэглээний бүтээгдэхүүнийг Улаанбаатараас татах замаар хангаж байгаа жимс, хүнсний ногооны үйлдвэрлэл маш бага, шаардлага хангасан зоорьгүй, сүү боловсруулах үйлдвэр байхгүй.

Харин хөгжлийн нөөц боломж, давуу талаа оновчтой ашиглах замаар байгаль орчинд халгүй дэвшилтэт техник технологид суурилсан үйлчилгээ, боловсруулах аж үйлдвэрийн салбарыг дэмжиж, монгол улсын болон Улаанбаатарын бүсийн хэмжээний эрчим хүч, уул уурхай, хими технологи, барилгын материалын хүнд аж үйлдвэрийн томоохон төв болгон хөгжүүлэх боломж харагдаж байна.

### ***Дүүргийн дэд бүтэц***

*Авто зам.* Багануур дүүрэг нь нийслэл Улаанбаатар хоттой 210 км урт төмөр замаар, 135 км авто замаар холбогдсон. Мянганы хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд байгуулагдсан авто зам дүүргийн нутаг дэвсгэрийг дайран өнгөрдөг. Багануур дүүргийн зонхилох тээвэр нь авто тээврээр гүйцэтгэгдэж байна.

*Төмөр зам.* Тус дүүрэг Ази, Европ тивийг холбосон босоо тэнхлэгийн олон улсын төмөр замтай 90 км төмөр замаар шууд холбогддог. Багануур Өртөө нь уурхайгаас жилдээ 3,0-3,2 сая тн нүүрсийг эрчим хүчний зориулалтаар нийслэл хот уруу тээвэрлэж байна.

*Цахилгаан хангамж.* Багануурт Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээний төв компани байрладаг бөгөөд 220 КВт-ын 150 орчим км урт шугамаар Төвийн бүстэй холбогдогдог. БНХАУ-ын зээлийн концессын гэрээгээр 2017 оноос 700 МВтын суурилагдсан хүчин чадал бүхий “Багануур цахилгаан станц”-ын I ээлжийг барихаар бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлж байна.

*Дулаан хангамж.* Дулааны станц нь дүүргийн төвөөс урагш 4.5 км зайд байрладаг. Дулааны станц нь КВТС-20 маркийн 8 зуухтайгаар нийт 160 геккалл/цаг хүчин чадлаар дүүргийн дулааны хэрэгцээг найдвартай хангаж байна. Гадна дулааны магистраль  $\varnothing 700\text{-}\varnothing 400$  мм-ийн голчтой, шугамын урт нь 9,2 км. Үйлдвэрийн район руу  $\varnothing 300$  мм-ийн голчтой дулааны шугамаар халаалт дамжуулдаг. Наран хороолол, үйлдвэрийн районы дулааны гол шугамууд нь газар дээр ил байдаг ба салаа шугамууд нь газар доор байрлалтай ажиллаж байна.

*Ус хангамж.* Багануур дүүргийн хүн амын унд, ахуй ба үйлдвэрийн ус хангамжийн эх үүсвэр нь Хэрлэн голын сав дагуух гүний усны 7 худагтайгаас 4 худаг нь ашиглагдаж байна. “Хэрлэн” станцаас олборлосон усыг “Наран” станцад дамжуулан хэрэглэгчдийг хангаж байна.

*Шүүрлийн ус.* ҮТП байгуулах төслийн талбайн баруун талд орших Багануур нүүрсний уурхайлалтын явцад газрын доорх усыг шүүрүүлж байна. Шүүрлийн ус нь Монгол Улсын “Хүрээлэн буй орчинд нийлүүлэх

цэвэршүүлсэн бохир усны ерөнхий шаардлага MNS4943:2011 стандартын шаардлагыг хангаж байгаа учир түүнийг Паркийн технологийн ус хангамжид ашиглах боломжтой .

*Ариутгах татуурга.* Багануур дүүргийн Цэвэрлэх байгууламж нь 4 коридороор бохир ус хүлээн авч одоогоор хоногт 8000м<sup>3</sup> усыг механик болон биологийн аргаар цэвэрлэж байна. Байгууламжийн суурилагдсан хүчин чадал нь 18000м<sup>3</sup>. Цэвэрлэгдсэн ус нь 3,5 км зайд төмөр бетон сувгаар, 8 км задгай урсаж Хэрлэн голд нийлдэг.

*Мэдээлэл холбоо.* Цахилгаан холбоо компанийн 7021 дугаартай тоон системийн болон суурин утасны сүлжээтэй. Мобиком, Юнител, Скайтел, G Мобайлын үүрэн сүлжээнд бүрэн холбогдсон. Миком, Мобинет, Скаймедиа өндөр хурдны шилэн кабелиудаар холбогдсон.

### ***Үйлдвэрүүдийг байгуулахад түшиглэх түүхий эд, материалын нөөц ба хангалтын судалгаа***

Багануурын бүс нь ашигт малтмалын хувьд нилээд сайн судлагдсан бөгөөд хайгуул судалгааны дүнд нүүрс, алт, болор, кальцедон, кварц, хайлуур жонш, бал чулуу, цагаан тугалга, шатдаг занар, шохой, элс, шавар, хайрга зэрэг эрдсийн түүхий эдийн ордууд илэрсэн болно. Эдгээрээс хамгийн том нь Багануурын нүүрсний орд газар.

Багануурын нүүрсний уурхай нь 812 сая тонн хүрэн нүүрсний нөөцтэй тогтоогдсон нөөцтэй, улсын хэрэгцээт нүүрсний 65%, төвийн бүсийн түлшний хэрэгцээний 78%-ийг хангадаг. Уурхайн хөрс хуулалтаас үүссэн 230-260 сая м<sup>3</sup> хөрсний овоолготой, 60 сая орчим тн исэлдсэн нүүрсний нөөцтэй.

Багануурын уурхайн хүрэн нүүрсний үйлдвэрлэлд түшиглэн хагас коксжсон нүүрс, шингэрүүлсэн түлш, хий, химийн үйлдвэрийн түүхий эд боловсруулах үйлдвэрүүд байгуулах нөөц боломж байна.

“Хуцаа” элс-хайрганы холимогын орд нь зүүн хойшоо сунаж тогтсон 2.8км урт, 0.5-0.8 км өргөн хэмжээтэй бөгөөд нийт нөөц 2984.8 мян.м<sup>3</sup> байна.

Барилга архитектурын Корпорацийн барилгын материалын итгэмжлэгдсэн лабораторид хийсэн шинжилгээгээр элс, хайрганы хольцыг бутлан ангилахад MNS 346:2000 “Барилгын ажилд хэрэглэх хайрга, буталсан хайрга” MNS 392:1998 “Барилгын ажилд хэрэглэх элс” стандартын шаардлагыг бүрэн хангасан элс, хайрга болох нь тогтоогдсон. Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооны итгэмжлэгдсэн лабораторын бетон хольцын туршилтаар өндөр маркийн бетон хольц үйлдвэрлэх сайн чанарын дүүргэгч болохыг тогтоосон. Мөн Багануурын Дулааны станцын үнсийг барилгын материалын үйлдвэрлэлд хольцоор ашиглах боломж ч бий.

Дайрганы ихээхэн нөөцтэй орд төвөөс урагш 5 км зайд оршдог бөгөөд одоо хувийн хэвшилд ашиглалтын лицензтэй байна. Анх 1979 онд тухайн үеийн нэрээр Зөвлөлт Холбоот Улсын Барилга угсралтын трест Багануурын уурхайн цогцолбор байгууламж, хотхоныг байгуулахад уг ордыг олборлон боловсруулж ашиглаж байв.



Энэ бүс нутагт барилгын материал, эрдэс түүхий эдийн нөөцүүд тогтоогдсон. Багануурын уурхайн үйл ажиллагаанаас гарч буй гүний ус, шавар, хайрга болон орон нутгийн барилгын материалын түүхий эдийг ашиглан ҮТП, их сургуулиудын хотхон, Улаанбаатар хотын шинэ бүтээн байгуулалтанд хэрэгцээтэй барилгын материал үйлдвэрлэлийг хөгжүүлэх нийтлэг боломж байна.

Түүнчлэн мах, сүү, малын дайвар бүтээгдэхүүн, эх орны эмийн ургамал, байгалийн гаралтай бусад түүхий эдийг ашиглан хүнсний болон биологийн идэвхит болон нано биотехнологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн дотоодын хэрэгцээг хангах, улмаар экспортод гаргах үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бололцоотой.

### **Мал аж ахуйн үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн байдал:**

Тус бүс нутгийг хөдөө аж ахуйн чиглэлээр хөгжүүлэх боломжийг харуулах зарим тоо материалыг авч үзвэл:

Зүүн бүсийн мал сүргийн тоо 2015 оны байдлаар бүгд 8,176.87сая, үүнээс адуу 704.12 сая, үхэр 648.68 сая, хонь 648.68 сая, ямаа2,810.98 сая,тэмээ17.27сая байна.

Манай улс2016 оны байдлаар 294,9 мян тн мах бэлтгэсэн бөгөөд үүнээс зүүн бүс 49,7 мян тн, аймгаар нь авч үзвэл Дорнод аймаг 10,3 мян/тн, Сүхбаатар31,5мян/тн, Хэнтий21,7 мян/тн.

Сүү нийт 765,3мян/тн бэлтгэсэн бөгөөд үүнээс зүүн бүс 117,9 мян/тн, аймгаар нь авч үзвэл Дорнод27,2 мян/тн, Сүхбаатар17,7 мян/тн, Хэнтий59,2 мян/тн.

Ноос нийт 22,3 мян/тн бэлтгэсэн бөгөөд үүнээс зүүн бүс 3,0 мян/тн, аймгаар нь авч үзвэл Дорнод 0,7 мян/тн, Сүхбаатар1,1 мян/тн, Хэнтий1,2 мян/тн.

Ноолуур нийт 7,7 мян/тн ноос бэлтгэсэн бөгөөд үүнээс зүүн бүс 0,8 мян/тн, аймгаар нь авч үзвэл Дорнод аймаг 0,1 мян/тн, Сүхбаатар 0,3 мян/тн, Хэнтий 0,3 мян/тн.

Нийт мал сүргийн 8,176.87сая буюу 14 хувь нь зүүн бүсэд байгаа бөгөөд мах бэлтгэлийн 17 %, сүү бэлтгэлийн 15 %, ноос бэлтгэлийн 13 %, ноолуур бэлтгэлийн 10 % -г нийлүүлж байгааг харахад малын гаралтай түүхийн эдээр эцсийн бүтээгдэхүүн хийх зориулалттай үйлдвэрийг байгуулах нөхцөл байгааг харж болно.

Маж, сүү, төмс, хүнсний ногоо, ноосны чиглэлээр өнөөдөр нөхцөл байдал ямар байгааг доор авч үзлээ.

### **Махны үйлдвэрийн салбарын өнөөгийн байдал:**

Манай улс бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг учраас улирлын шинж чанартай мах бэлтгэл хийдэг онцлогтой. 2015 оны урьдчилсан дүнгээр 14.5 сая толгой мал хүнсэнд хэрэглэж, хөдөө аж ахуйгаас 357.5 мянган тонн махыг бэлтгэсэн нь өмнөх оныхоос 68.5 хувиар нэмэгдсэн байна. Үйлдвэрийн

аргаар 17.5 мянган тонн махыг боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний хэмжээ өмнөх онтой харьцуулахад 0.7 мянган тонноор нэмэгдэж, боловсруулалтын түвшин 4.9% байна. 2015 онд 5.2 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн экспортолсон нь 2014 оныхоос 2 дахин нэмэгдсэн байна.

Хэдийгээр мах экспортлох хэмжээ өсөх хандлагатай байгаа ч импорт төдийлөн буурахгүй байгаад дүгнэлт хийх шаардлагатай.

Улсын хэмжээнд мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн тоо:

- Малнядлах, эхлэн боловсруулах- 4
- Хиам, нөөшилсэн бүтээгдэхүүн- 131
- Хагас боловсруулах- 21

Дээрх нядалгааны үйлдвэрүүд нь ихэвчлэн экспортод чиглэсэн үйл ажиллагаа эрхлэдэг бөгөөд 10 гаруй үйлдвэр нь тогтмол үйл ажиллагаа явуулдаг.

Багануур дүүргийн тухайд “Мах маркет” ХХК-ийн салбар мах боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа нь түр зогссон байна. Мал нядалгааны нэг цэг одоогоор ажиллаж байна.

#### **Сүүний үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн байдал:**

Монгол Улсад 2015 оны байдлаар сүүний гол нөөц болох үхэр сүрэг 4,08 сая толгой, үнээ 1,6 сая толгой байна. Зүүн бүсийн үхэр сүргийн тоо 0.65 сая, үнээ 0.25 сая байна.

Улсын хэмжээнд 2014 онд хөдөө аж ахуйгаас 765,4 сая литр сүү бэлтгэсэн нь өмнөх онтой харьцуулахад 14,7 хувиар, мөн шингэн сүү 28,3 сая литр үйлдвэрлэсэн нь 6,4 хувиар, цөцгий, цөцгийн тос 1450,5 тн үйлдвэрлэсэн нь 21,7 хувиар тус тус өссөн байна. 2015 оны эхний хагас жилд үйлдвэрийн аргаар 14,1 сая литр сүү боловсруулсан байна.

2015 онд Монгол Улсын нийт хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэгцээ шингэн сүүнд шилжүүлснээр 459,8 сая литр байна. Хэдийгээр нийт бэлтгэсэн сүүний хангамж 169,1 хувьтай, үйлдвэрийн аргаар боловсруулсан дотоодын болон импортын сүү, сүүн бүтээгдэхүүний хангамж 19 хувьтай байна. Улсын хэмжээнд хоногт 230.0 гаруй мянган литр сүү боловсруулах хүчин чадалтай нийт 100 гаруй үйлдвэр, цех байгаагаас Улаанбаатар хотод 45 нь үйлдвэрлэл эрхлэж байна.

#### **Дүгнэлт:**

- Улс даяар бэлтгэж байгаа сүүний хэмжээ хэрэгцээнээс 70% орчим давж байхад 28,0 сая гаруй ам долларын үнэ бүхий сүү, сүүн бүтээгдэхүүнийг импортолдог буруу тогтолцоог эрс өөрчлөх шаардлагатай байгааг стратегид тусгах хэрэгтэй.
- Засгийн Газрын аймаг хотуудыг түшиглэн хуурай сүүний үйлдвэр байгуулах бодлогын хүрээнд Багануур дүүрэгт ийм үйлдвэр барих арга хэмжээг Дүүргийн удирдлагатай хамтарч авах хэрэгтэй.

## Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл, зоорь хангамж

Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл нь улирлын чанартай бөгөөд байгаль орчин, цаг уураас ихээхэн хамааралтай нь сүүлийн 3 жилийн дүн мэдээллээс харагдаж байна.

**Хүснэгт 2. Төмс, хүнсний ногооны хэмжээг онуудаар үзүүлбэл: /статистикийн нэгдсэн сангийн мэдээллээс 2017.08.09/**

Аймаг	Төрөл	2014	2015	2016
Улсын дүн	Төмс	161,488.5	163,766.9	165,329.5
Улсын дүн	Хүнсний ногоо	104,791.9	72,347.6	94,447.2
Зүүн бүс	Төмс	8,038.8	6,616.3	6,882.2
Зүүн бүс	Хүнсний ногоо	5,201.9	3,985.	3,740.5
Улаанбаатар	Төмс	4,334.6	3,101.9	2,846.6
Улаанбаатар	Хүнсний ногоо	5,527.5	3,758.	5,434.

Дүүрэгт хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалдаг ЖДҮ, өрхийн үйлдвэрлэгчид 38 нэгж байна.

Тариалалт жилээс жилд нэмэгдэж байгаа хэдийч хураасан ногоогоо зөв хадгалж, хэрэгцээг тасралтгүй жигд хангах, зохистой түгээлтийн системийг нэвтрүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж, улмаар импортлох хэмжээг доод түвшинд хүргэх бодлого баримтлах хэрэгтэй байгаа.

Улсын хэмжээнд 2014 оны байдлаар 182,2 мянган тонн багтаамжтай 3600 гаруй зоорь ашиглаж байна. Зоорийн нийт багтаамжийг хураан авсан ургацтай харьцуулахад хадгалах хүчин чадлын хангамж 2014 онд 71,5 хувьтай байна.

**Зураг 2.**




Багануур дүүргийг байгуулж байх үед Зөвлөлтийн хүч хөрөнгөөр баригдсан одоогийн “Мах маркет” ХХК-ийн салбар, “Мон цахим” ХХК, хуучнаар “Төмөргүйжүүлэх станцын ногооны томоохон зоориудыг түрээслэх журмаар ашиглаж байна. Гэрийн энгийн нүхэн зоорьтой цөөн айл өрх бий. Гэвч багануурчууд өөрийн тарьсан ногоог хүйтний улиралд зоорилож хадгалан орон нутгийнхаа зах зээлийг хангаж чадахгүй байна.

Оршин суугчдын хүнсний аюулгүй байдлыг эрхэмлэж дүүрэг өөрөө өөрийгөө хүнсээр хангах тогтвортой бодлогыг явуулах шаардлага ч байгаа юм. Үүнд л чиглүүлж Парк хүнсний үйлдвэрүүдийг байгуулах ажиллагааг өрнүүлэх хэрэгтэй. Хүнсний тухай хуулийн 3.1.6-д “**стратегийн хүнс**” гэж монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай малын мах, сүү, тарианы үр, улаан буудай, гурил, ундны усыг тодорхойлсны дагуу Парк өөрийн бодлогодоо мөрдлөг болгоно.

### Ноосны нөөцийн тухайд

Улсын хэмжээнд 30 орчим мянган тн ноос бэлтгэх нөөцтэй боловч хяргасан ноосыг түүхий эд бэлтгэх газар цуглуулан жилдээ 20.000-22.000 тн ноос бэлтгэж угаасан ноосыг бэлтгэн нийлүүлдэг мэдээтэй байна.

**Зураг 3.**



Дотоодын томоохон үйлдвэрүүд болох

- Эрдэнэт хивс ХХК - 3000 тн
- Нэхээсгүй эдлэл ХХК - 1500 тн
- Могол ноос ХХК 1800-2000 тн ба нийт 6500 тн буюу нийт ноосны 28 хувийг угааж, ноос болон ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд нийлүүлдэг. Харин 50 орчим хувь буюу ойролцоогоор 11800 тн ноосыг Хятад улс уруу хямд үнээр экспортлон, үлдсэн хэсэг нь ашиглагдахгүй хаягддаг.

ҮТП-ийн үйл ажиллагааг дэмжих, дагаж хөгжих боломжтой хөнгөн, хүнсний салбарын үйлдвэрүүдийг тус дүүрэг байгуулж, оёмол, сүлжмэл, мах, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрүүдийг тус дүүрэгт байгуулж, нийслэл орон нутгийг хангах улмаар экспортод гаргах чиглэлийг баримтлан кластераар хөгжүүлэх нь чухал байна.

## ХОЁР. “БҮТП” ОНӨТҮГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

### Паркийн дээд удирдлага

“Багануур Үйлдвэрлэл, Технологийн Парк” ОНӨТҮГ-н дээд удирдлага нь Засгийн газрын эрх бүхий байгууллага буюу Уул Уурхай Хүнд Үйлдвэрлэлийн Яам юм.Яам нь:

1. Парк үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох,
2. Парк ба үйлдвэрлэлийн хөгжлийн чиг хандлагыг тогтоох,
3. Паркийн удирдлагатай үйл ажиллагааны гэрээ байгуулах,
4. Паркийн хөрөнгө оруулалтын бодлогыг дэмжиж, Засгийн Газрын хөрөнгийн баталгаа гаргах ажлыг гүйцэтгэх,
5. Паркийн дэд бүтцийг байгуулах зураг төслийг гаргуулах, байгуулах санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх,
6. Паркийн хөгжлийн хөтөлбөрийг баталж мэргэжлийн удирдлагаар хангах,
7. Паркийн үйл ажиллагаанд хяналт тавих зэрэг чиг үүрэгтэй оролцож байгаа

Парк нь дэд бүтцийн барилга байгууламжийг барих асуудлаар БХБЯ, эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн асуудлаар БСШУЯ, хөнгөн ба хүнс, газар тариалангийн асуудлаар ХХААХҮЯ, хөрөнгө оруулалтын асуудлаар ҮХГ зэрэг төрийн удирдах байгууллагуудтай харилцаж өдөр тутмын үйл ажиллагаагаа уялдуулж байгаа болно.

### Нийслэлийн Засаг дарга нь:

- Паркийн хөгжил, үйлдвэржилтийн чиг хандлагыг нийслэлийн хөгжлийн бодлоготой уялдуулан тогтоох,
- УУХҮЯ-тай хамтран Паркийн удирдлагатай гурвалсан гэрээ байгуулах,
- Орон тоо, төсөв батлах, санхүүжүүлэх, төсвийн зарцуулалтад хяналт тавих,
- Паркад эзэмшлийн газар олгох, хяналт тавих,
- Паркийн дэд бүтцийг байгуулах зураг төслийг гаргуулах, барих санхүүжилтийн шийдвэрлүүлэх асуудлыг бусад Яамдуудтай хамтран шийдвэрлэх,
- Мэргэжлийн удирдлагаар хангах,
- Паркийн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй оролцдог.


### Дүүргийн Засаг дарга:

- Паркийн хөгжил, үйлдвэржилтийн чиг хандлагыг дүүргийн хөгжлийн бодлоготой уялдуулах,
- Парк хөгжлийн сан байгуулах,
- Орон нутгийн дэмжлэг үзүүлэх,
- Хөрөнгө оруулагчидтай холбох,
- Паркад эзэмшлийн газар олгох, хяналт тавих зэргээр хамтран ажилладаг.

### Хамтран ажиллах байгууллага:

- Эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулиуд,
- Гааль,
- Татвар,
- Банк санхүү,
- Мэргэжлийн хяналт,
- Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим,
- Сургалт, сурталчилгааны байгууллага,
- Дотоод гадаадын хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчид юм.

Схем 1. Паркийн дээд удирдлагын бүдүүвч:



Паркийн удирдлага /дарга/ нь Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яамтай паркийн үйл ажиллагаа эрхлэх гэрээ байгуулж, 2017 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг УУХҮЯ-ны Төрийн Нарийн бичгийн дарга, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаар батлуулж мөрдөн ажиллаж байна.

Паркийн удирдлагын схем, мэргэжлийн чиглэл, удирдлага өгөх болон хамтран ажиллах байгууллагуудыг нарийвчлан тогтоон гаргаж байгаа нь парк, түүний үйл ажиллагаатай хамаарах хүрээнд кластерийн удирдлагыг нэвтрүүлэх, логистик төв байгуулах боломжийг тодорхойлоход чиглэж байгаа болно.

### **Паркийн захиргаа /бүтэц, орон тоо, хөрөнгө, санхүү, байр/**

“БҮТП” ОНӨТҮГ газар нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 07 сарын 03-ны өдрийн 122 тоот тогтоолоор байгуулагдаж 14 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Схем 2



**Хүснэгт 3. Паркийн захиргааны ажиллагсдын мэргэжил, боловсролын түвшинг үзүүлбэл:**

№	Мэргэжилтэн	Боловсролын зэрэг	Тоо
1	Уул уурхайн механик инженер	Бакалавр	1
	Бизнесийн удирдлагын менежер	Магистр	1
	Нягтлан бодох бүртгэл	Бакалавр	1
2	Уул уурхайн инженер-цахилгаан механикч	Магистр	1
	Уул уурхайн зөвлөх инженер		1
3	Нягтлан бодогч, эдийн засагч	Бакалавр	1
	Хүний нөөцийн менежер	Сертификат	1
4	Биологч, биологийн багш	Бакалавр	1
	Төрийн ударлага	Магистр	1
5	Англи хэлний багш, орчуулагч	Бакалавр	1
6	Газрын менежер	Бакалавр	1
	Төрийн удирдлага	Магистр	1
7	Маркетинг	Бакалавр	1
8	Олон улсын худалдаа, бизнесийн менежмент	Бакалавр	2
9	Мал эмнэлзүйч	Бакалавр	1
	Нярав мэргэжил	Мэргэжилийн үнэмлэх	1
10	Олон улсын эдийн засагч	Магистр	1
	Хүний нөөцийн удирдлага	Бакалавр	1
	Нягтлан бодох бүртгэл	Сертификат	1
11	Барилгын инженер/ дулаан хангамжын инженер/	Бакалавр	1
12	Газрын тосны инженер	Бакалавр	1
	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй	Сертификат	1


Үүнд: мэргэжлийн давхардсан тоогоор 14 хүн бакалавр, 5 магистр, 4 мэргэжлийн үнэмлэх сертификаттай байна. Паркийн нөнөөгийн удирдлагын хүний нөөцийн бүрэлдэхүүнд хийсэн судалгаанаас: Энэ графикт үзүүлснээр “БҮТП” ОНӨТҮГазарт 26% нь магистрийн зэрэгтэй, үлдсэн 76% нь бакалаврийн зэрэгтэй байна.

**Зураг 4.**



**Зураг 5.**





Энэ графикт үзүүлсэнээр 57 % залуучууд ажиллаж байгаа нь харагдаж байна.

**Зураг 6.**



Энэ гарафикт үзүүлсэнээр 2021 он гэхэд 6 хүн магистр, 6 хүн докторын зэрэгтэй болох боломтой байна.

Паркийн стратегид хүний нөөцийн дараах судалгаануудыг хийж, дүгнэлтүүдийг тусгах шаардлагатай байдаг. Гэвч тус Паркийн захиргаа байгуулагдаад удаагүй, ажилтнууд нь шинэ тутам бүрдэж байгаа зэрэг нөхцлийг харгалзан уг асуудлыг стратегийн төлөвлөгөөнд оруулж гүйцэтгэнэ. Үүнд:

- Ажилтнуудын мэргэжил, боловсролын төвшинд хийсэн судалгааны дүн.
- Ажилтнуудын ур чадвар, ажилд хандах сэтгэл, үнэнч байдал.
- Биеэ дайчлах, өөрийгөө хөгжүүлэх идэвх, санаачлага.
- Ажлын байрны хронометраж, дүгнэлт.

#### **“БҮТП” ОНӨТҮГазрын үйл ажиллагааны 2017 оны санхүүжилт**

**Хүснэгт 4. БҮТПарк үйл ажиллагааны урсгал зардлын товчоо. 2017он**

Үйл ажиллагааны урсгал зардлын ерөнхий зориулалт	Батлагдсан дүн
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	226,937.0
Урсгал зардал	226,937.0
Бараа, үйлчилгээний зардал	226,937.0
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	164,582.8
Үндсэн цалин	128,400.0
Нэмэгдэл	25,680.0
Унаа хоолны хөнгөлөлт	10,502.8
А/О нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,103.6
Тэтгэврийн даатгал	11,520.4
Тэтгэмжийн даатгал	1,316.6
ҮОМШ-	1,645.8
Ажилгүйдэлийн даатгал	329.2
Эрүүл мэндийн даатгал	3,291.6
Байр холбоотой тогтмол зардал	23,250.6
Гэрэл, цахилгаан	1,884.8
Түлш, халаалт	12,263.3
Цэвэр, бохир ус	56502.5
Байрны түрээс	3,600.0
Хангамж, бараа материалын зардал	7,000.0
Бичиг хэрэг	3,500.0

**Хүснэгт 5. БҮТПарк хөрөнгө санхүү, төсвийн хувиарлалт 2016-2017.**

Үйл ажиллагааны урсгал зардлын ерөнхий зориулалт	Батлагдсан дүн
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,000.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500.0
Томилолт, зочны зардал	1,000.0
Дотоод албан томилолт	1,000.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний т/хураамж	12,000.0
Б/Г бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	12,000.0
Урсгал шилжүүлэг	1,000.0
Бусад урсгал шилжүүлэг	1,000.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000.0
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	226,937.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих	226,937.0
Орон нутгийн төсвөөс	226,937.0
Төсвийн бусад мэдээллийн ангилал	15.0
Байгууллагын тоо	1.0
Төсвийн байгууллага	1.0
Ажиллагсдын тоо	14.0
Удирдах ажилтан	1.0

**Дүгнэлт:** 1.Үйл ажиллагаа өргөжихөд батлагдсан төсөв ялангуяа дотоод, гадаадын техник, технологийн үзэсгэлэн, уулзалт, зөвлөлгөөнд оролцох, судалгаа, шинжилгээ, сурталчилгааны ажил зэрэгт хүрэлцэхгүй болж байна.

2.Санхүүжилтийг жилд 100,0-120,0саяаар нэмэгдүүлэх шаардлага байна.

### **Захиргааны байр:**

2010 онд ХХААЯ /хуучин нэрээр/ одоо УУХҮЯ-ны өмчинд бүртгэлтэй байгаа Багануур ҮТП-ийн захиргааны зориулалттай 1068м<sup>2</sup> талбай бүхий байрыг дүүргээс худалдан авсан байдаг. Өнөөдрийн байдлаар Яамнаас уг барилгыг ҮТПаркад шилжүүлээгүй бөгөөд шууд ашиглах боломжгүй, даацын хана нурсан, хаалга цонх байхгүй, шугам хоолой ашиглалтгүй удаж балгас болсон. Сэргээн засварлаж ашиглахад 1,5 тэрбум орчим төгрөг шаардагдах урьдчилсан тооцоо гарсан.

### **Зураг 7. Багануур ҮТП-ийн захиргааны зориулалттай байрны өнөөгийн байдал. 2017он**



### **Дүгнэлт:**

1.ҮТП-ийн захиргааны зориулалттай байрыг цаашид хэрхэн ашиглах талаар санал боловсруулж асуудлыг УУХҮЯаманд яаралтай тавьж шийдвэрлүүлэх хэрэгтэй.

2.Одоогоор захиргаа нь “Мэдээлэл,холбоо сүлжээ” компанийн байранд түрээсэлж байна.

### **Паркийн гадаад харилцаа, мэдээлэл, сурталчилгаа**

Паркийн үйл ажиллагааны нэг хэсэгт түүнийг нийтэд сурталчлах, хөрөнгө оруулагчдад зөв мэдээлийг хүргэх, солилцох, хамтрах чиглэлүүдийг судлах зэрэг олон арга хэмжээ байдаг.

Монгол, англи хэл дээр бэлтгэсэн паркийн мэдээлэл, танилцуулгыг өөрийн орны болон олон улсын хэмжээнд зохиогдсон шинжлэх ухаан, техник, технологи, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний үзэсгэлэн, яармаг, уулзалт,

зөвөлгөөнд оролцох үеэрээ компани, бизнесийн байгууллага, хөрөнгө оруулагчдад хүргэж байна. Энэ онд “Улаанбаатар-Хөрөнгө оруулалт 2017” Бизнес уулзалт, “Монгол, Хятад хоёр улсын 2 дахь удаагийн” Экспо үзэсгэлэн”, “Экспо монголиа-2017”, Байгаль орчинд ээлтэй техник технологийн үзэсгэлэн болон Улаанбаатар хот, Багануур дүүрэгт зохиогдсон нээлттэй хаалганы өдөрлөгүүдэд оролцов.

“Baganuur-itp.mn”цахим хуудсыг нээж, англи, монгол хэлээр мэдээллүүдийг оруулж, идэвхтэй хөтөлж байгаагаас гадна “Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим”-тай гишүүнчлэлийн гэрээ хийж байна.

Гадаад харилцаа, мэдээлэл, сурталчилгааны ажлыг идэвхжүүлэхэд зарцуулах мөнгө хүрэлцэхгүй байгааг тооцоолж нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

### **Паркийн нэгж ба үйлдвэрлэл / үйлдвэрийн бүсчлэл, байршлын төлөвлөгөө, дэд бүтэц/**

Дүүрэгт ҮТП-ийн хүрээнд нийт 21 үйлдвэрийн төсөл хэрэгжихээр төлөвлөгдөж байв. Төслүүдийн товчоог хавсралтаар оруулав.

Багануур үйлдвэрлэл технологийн паркад байгуулахаар төлөвлөсөн үйлдвэрүүдийн төслийн хэрэгжилтийн талаар хийсэн судалгааны дүн:

1. Нано Биотехнологийн Адуу брэнд цогцолборын үйлдвэрийн үйл ажиллагаа нь явагдаж эмийн болон гоо сайхны бүтээгдхүүн үйлдвэрлэж байна. Цаашид шинэ технологийг бүрэн нэвтрүүлж үйлдвэрийн өргөтгөлийг хийх төлөвлөгөөтэй байна.
2. Мах махан бүтээгдэхүүн ба сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл “Хайбайт” ХХК, АБЗН ХХК- нь өөрийн төслийг Багануурт хэрэгжүүлэхгүй болсон. Иймд дээрх төслүүдийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчийг татах арга хэмжээ авах шаардлагатай байна.
3. Багануур ХК нь одоогоор өөрийн үйлдвэрийн дотоод хэрэглээнд зориулан уурхайн эдэлбэр газар дахь хайрга ангилан ашиглаж байна.
4. Багануур ХК нь нүүрс баяжуулах болон гумины бордооны үйлдвэрүүдийн төслийг хэрэгжүүлэх хөрөнгөний асуудлыг шийдвэрлэхээр арга хэмжээ авч байгаа боловч тодорхой үр дүнд хүрээгүй байна.
5. Биологийн нөхөн сэргээлтийн төслийг Араг булаг ХХК хэрэгжүүлж байгаа бөгөөд одоогоор 10.7 га талбайд нөхөн сэргээлтэнд ашиглах мод үржүүлэгийн тариалалт эрхэлж байна. Энэхүү ашиглалтын талбай нь Паркийн талбайгаас зайтай орших учир нэгжээр орох боломжгүй байгаа болно.
6. “Багануур” ХК нь мод үржүүлгийн газар, гүний усыг цэвэршүүлэх үйлдвэрийн төслүүдийг хэрэгжүүлэхээр зорьж байгаа ч хөрөнгө санхүүжилтийн асуудлаас үүдэн зогсонги байдалд байна.
7. MCS+POSCO+Багануур энерги корпорэйшн ХХК-н хэрэгжүүлэх нүүрс шингэрүүлэх үйлдвэрийн төсөл нь дэлхийн зах зээл дэх нефть бүтээгдэхүүний үнийн уналтаас үүдэн зогссон байна.

8. Багануур ХК-н аялал жуулчлалын бааз байгуулах өөрийн төслийг хэрэгжүүлэх ажлыг дүүрэгт “Шувуун саарал” нэртэй аялал, жуулчлалын цогцолбор барьж эхэлсэнтэй холбогдуулан хойшлуулсан.
9. Хөнгөн блокны үйлдвэрийн хаягдалгүй технологийг уурхайлалтын явцад гарч байгаа хөрсний шорооны баяжуулсан элсээр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зориулж боловсруулсан. Одоогоор Багануур ХК нь шороогоо баяжуулах үйлдвэрийг байгуулаагүй учир энэхүү төсөл нь хүлээгдэж байна.
10. Ангижруулсан төмрийн үйлдвэрийг барихаар ҮХЯаманд санал ирүүлсэн Энэтхэг улсын “Жандал” компани хөрөнгө оруулалтаа хойшлуулсан тул Багануур ХК нь төслийг хэрэгжүүлээгүй байна.

Дээрх төслүүдийн хувьд дараах ажил хэргийн чанартай арга хэмжээ авах нь зүйтэй болохыг тэмдэглэж байна.

- Эдгээр үйлдвэрүүдийн төслүүд нь хэдийгээр боловсруулагдсан, цаашид хэрэгжих боломжтой боловч хөрөнгө оруулалт нь тодорхой бус учраас уг төслүүдийг хэрэгжүүлэх хугацааг нь хойшлуулж үйлдвэрүүдийг ойрийн төлөвлөгөөнд тусгахаас татгалзаж хэтийн төлөвлөгөөнд оруулах,
- Хөрөнгө оруулалт нь бодитоор орж ирэх төслүүдийг стратегийн ойрын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх,
- Паркийн зүгээс дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрүүдэд дэвшилтэд технологи, орчин үеийн машин, тоног төхөөрөмж нэвтрүүлэх замаар өргөтгөл хийж шинэ бүтээгдэхүүн гаргах үйл ажиллагааг дэмжих бодлогыг баримтлах,
- Паркад үйлдвэр байгуулахаар судалгаа хийж харилцан холбоотой байгаа компаниудыг татах, дэмжих арга хэмжээ авах,
- ЖДҮ-ийг өргөжүүлж хөгжүүлэх талаар Дүүргийн захиргаатай хамтран ажиллах зэрэг болно.

### **Эрдэм шинжилгээ туршилт судалгаа**

Паркийн захиргаа нь хөгжлийн 2017- 2025 оны төлөвлөгөөнд 17 үйлдвэрийг байгуулахаар тусгасан бөгөөд өнөөдрийн байдлаар хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр Герман улсын хөрөнгө оруулалттай “Нүүрс шингэрүүлэн дизель түлш үйлдвэрлэх” төсөл хэрэгжүүлэх “Монгол Шингэн Нүүрс” ХХК- тай нэгжийн 2017/001 тоот гэрээг 5-р сарын 23-ний өдөр байгуулан ажиллаж байна.

Мөн хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр “Ноос, ноолуур гүн боловсруулах” үйлдвэр байгуулах төсөл хэрэгжүүлэх “Силкроуд Аёори Монгол” ХХК, нанобиотехнологийн чиглэлээр “Малын гаралтай биотехнологийн эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн цогцолбор барьж байгуулах” төслүүдийг хэрэгжүүлэх ШУҮ-ийн “Монхимо” ХХК-иуд паркад газар эзэмших гэрээ, нэгжийн гэрээ байгуулж байна.

Багануур ҮТПаркад байгуулах үйлдвэрүүдийн чиглэлийг тогтоох, тэдгээрийн техник, технологи, түүхий эдийг судлахаар гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилтын ажлууд.

**Хүснэгт 6.**

№	Захиалагч байгууллага	Гүйцэтгэгч Байгууллага	Судалгаа, туршилтын ажлууд.
1	Багануур ХК	ОХУ. Красноярск хот. Карбоника, Сибтермо э/ш, туршилт үйлдвэрлэлийн ХХК	Багануурын нүүрсийг хийжүүлэх, коксжуулах, брикетлэх лабораторийн болон хагас үйлдвэрлэлийн 5тн дээжинд хийсэн туршилт. ЭЦТЭХЦогцолборийн төсөл хамтран боловсруулав
2	Багануур ХК	Төв цэвэрлэх байгууламжийн лаборатори, Нийслэлийн мэргэжлийн хяналтын усны лаборатори	Карбоника үйлдвэрт Багануурын нүүрснээс гаргасан идэвхжүүлсэн нүүрсээр шүүлт хийсэн туршилт, судалгааны ажил: 1. УБ-ын Төв цэвэрлэх байгууламжаас Туул голд хаягдаж байгаа усыг шүүсэн лабораторийн дүн, 2. Ноос, ноолуурын үйлдвэрээс хаягдаж байгаа усыг шүүсэн лабораторийн дүн, 3. Хотын машин угаалгын газраас хаягдаж Багануур ХК байгаа усыг шүүсэн лабораторийн дүн,
3	Багануур ХК	ШУТИС. Эрчим хүчний их сургууль	Багануурын Дулааны төв станцын түлшийг нүүрсний хийд шилжүүлэх боломжийг тодорхойлох судалгаа
4	Багануур ХК	БНХАУ. Бээжин хотын туршилт үйлдвэрлэлийн ХХК	Багануурын нүүрсээр брикет хийх туршилт, /40кг дээжинд/
5	Багануур ХК	Дархан.Шарын гол Энерго ХХК	Багануурын нүүрсийг хийжүүлэх, коксжуулах үйлдвэрлэлийн туршилт,/ 195тн дээжинд/
6	Багануур ХК	Хатуу түлш ХХК	Шарын гол Энерго үйлдвэрт Багануурын нүүрснээс гаргасан хагас коксоор брикет хийсэн туршилт, судалгаа
7	Багануур ХК	Хими, хими технологийн хүрээлэн	Багануурын исэлдсэн нүүрсээр гумины бордоо хийх туршилт, судалгааны ажил Гумины бордооны үйлдвэрийн төсөл хамтран боловсруулав
8	Багануур ХК	Эрдэс боловсруулалт, технологийн хүрээлэн	Багануурын нүүрсийг /1тн дээж/ нойтон баяжуулах туршилт, судалгааны ажил
9	Багануур ХК	МУИС. Хими, хими инженерчлэлийн сургууль	Багануурын нүүрсийг хийжүүлэх, химийн бүтээгдэхүүн гарган авах лабораторийн судалгаа
10	Багануур ХК	МУИС. Хими, хими инженерчлэлийн сургууль	Багануурын хөрс хуулалтын цагаан шороонд ГИБ-ын нөлөөлийг тодорхойлох лабораторийн судалгаа
11	Багануур ХК	МУИС. Хими, хими инженерчлэлийн сургууль	Багануурын уурхайн гүний шүүрүүлэлтийн усыг шүүж цэвэршүүлэх лабораторийн судалгаа. Шүүрүүлэлтийн усыг шүүж цэвэршүүлэх үйлдвэрийн төсөл хамтран боловсруулав
12	Багануур ХК	МУИС. Цөмийн судалгааны төв	Багануурын уурхайн хөрс, элс хайрганы холимог, нүүрсний давхарга, гүний шүүрүүлэлтийн усан дахь цацрагын хэмжээг тогтоох шинжилгээ судалгаа


13	Багануур ХК	ХБНГУ. Кеолн хот.	Багануурын нүүрсний баяжицыг тодорхойлох, нойтон баяжуулалтын үйлдвэрийн технологийн схем боловсруулах, лабораторийн туршилт, судалгаа. Жилийн 1,0сая тн нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн санал авав
14	Багануур ХК	БАК-ийн шинжилгээ, туршилтын лаборатори	Багануурын уурхайн хөрсний элс хайрганы холимогийг Барилгын материалд ашиглах боломжийг тодорхойлох лабораторийн судалгаа
15	Багануур ХК	БАК-ийн шинжилгээ, туршилтын лаборатори	Багануурын хөрс хуулалтын цагаан шорооноос барилгын түүхий эд, материал гарган авах лабораторийн туршилт, судалгаа
16	Багануур ХК	Судалгаа хөгжлийн хэлтэс	Багануурын хөрс хуулалтын цагаан шороог баяжуулах туршилт
17	Багануур ХК	Инова хөнгөн блокны үйлдвэр	Багануурын хөрс хуулалтын цагаан шорооноос Багануурын хөрс хуулалтын цагаан шороог баяжуулахад ГИБ ашиглах туршилт судалгаа хөнгөн блок хийх хагас үйлдвэрлэлийн туршилт
18	Багануур ХК	ШУТИС. УУИС	Багануурын хөрс хуулалтын цагаан шороог баяжуулахад ГИБ ашиглах туршилт судалгаа
19	Багануур ХК	ШУТИС. БИАС	Багануурын хөрс хуулалтын цагаан шорооноос ГИБ ашиглан баяжуулж гарган авсан элсээр барилгын түүхий эд, материал хийхэд үзүүлэх нөлөөлийн лабораторийн туршилт судалгаа
20	Багануур ХК	Судалгаа хөгжлийн хэлтэс	Цагаан шорооны баяжуулсан элсийг бетон шалны болон ханын өнгөлгөөнд ашиглах туршилт

Жич: Дээрх судалгаа, туршилтуудтай холбоотой ажлын зураг, схем болон бусад нөхцөл байдлын судалгаа тооцоог стратеги төлөвлөгөөний хавсралтад оруулж өглөө.

### “БҮТП” ОНӨТҮГ-ын 2017-2020 оны дунд хугацааны стратегийн төлөвлөгөөний уялдаа холбооны бүдүүвч

Схем 4. Хөгжлийн үзэл баримтлал болон стратеги төлөвлөгөөний уялдаа





**Эрхэм зорилго:**

Эрчимтэй хөгжлийн шинэчлэл нь Үйлдвэрлэл, технологийн парк байна.

**Алсын хараа:**

Олон улсын жишигт нийцсэн эко үйлдвэрлэлийн парк болох

**Суурь Үнэт зүйлс:**

- ❖ Чадварлаг, эвсэг менежментийн баг
- ❖ Найдвартай дэд бүтэц
- ❖ Үйлдвэрлэлийн бодит хөрөнгө оруулалт
- ❖ Итгэлтэй түншлэл

**ҮР ДҮН**

Шинжлэх ухааны үндэслэлтэй концепци, үзэл баримтлалд тулгуурласан хөгжил, шинэчлэлийн бодлогыг Монгол Улсын үйлдвэржилт, инновацийн бодлого, хууль эрх зүйн орчинтой нягт уялдуулан боловсруулж хэрэгжүүлснээр “БҮТП” ОНӨТҮГ-ын тогтвортой ажиллагаа хангагдан, экологид ээлтэй, үр ашигтай үйлдвэрлэл, технологийг хөгжүүлэх боломж бүрдэнэ.

**Дунд хугацааны стратегийн төлөвлөгөө /2017-2020/**

**Хөтөлбөрийн нэр**

Паркийн захиргааны хүний нөөцийг чадавхжуулах хөтөлбөр  
 Үйлдвэрийн байгаль орчны нөлөөллийг бууруулах хөтөлбөр  
 Үйлдвэрийн чиг хандлагын менежментийн хөтөлбөр  
 Паркийн эдийн засгийн хувьд бие даасан байдлыг хангах хөтөлбөр

**Хэрэгжүүлэх нэгж, хэсэг**

ЗА  
 ҮТА, Удирдлага  
 ЗА, ҮТА, Удирдлага  
 ҮТА, ЗА, Удирдлага

**Хүснэгт 8.**

<b>SWOT шинжилгээ</b>					
<b>ГАДААД ОРЧИН</b>					
1	Үндсэн хөрөнгийн татвар, ААН-н орлогын албан татвар, газрын татвараас чөлөөлөх зэрэг хөнгөлөлтүүдийг паркийн нэгжид үзүүлэх боломжтой.	Эдийн засаг хүндэрсэн нь хөрөнгө оруулалтыг багасагах аюултай. Аж үйлдвэржилтийн эрчимжилтийн бууралт нь хэрэглээг бууруулах талтай.	1	Парк эзэмшил газартай.	Агаарын тээвэр байхгүй.
2	Зүүн бүсийн ложистик төв байх боломжтой	Төлөвлөгдсөн төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт удаашрах магадлалтай	2	Зүүн бүстэй холбосон төв авто замтай шууд холбоотой.	Одоогоор уурын халаалтын зуух байхгүй
3	Хүн амын суурьшилт ихсэж байгаа учраас ажиллах хүчийг	Байгалийн болзошгүй гэнэтийн хүчин зүйл	3	Ази, Европыг холбосон төмөр замтай шууд	Үйлдвэрлэлийн зориулалттай цэвэрлэх



	хямд зардлаар ажиллуулах боломжтой.			холбогдсон	байгууламж байхгүй /500м3/.
4	Албан ёсны зөвшөөрөл, баталгаа, эрхийн бичиг авахтай холбогдсон хуулийн болон бусад зөвлөгөөг паркаас авах боломжтой.	Засгийн газрын ҮТП-ийн тухай баримтлах бодлого, тогтворгүй байдлаас хөрөнгө оруулагчид болгоомжлох магадлалтай.	4	Дэд бүтцийн байгууламжийн хувьд давуу талтай	Үйлдвэрийн хуурай, нойтон хог хаягдлыг боловсруулах үйлдвэргүй.
5	МСҮТ–тэй хамтран мэргэшсэн ажилчдыг бэлтгэх боломжтой.		5	700мвт хүчин чадалтай дулааны станц 3,5 жилийн дараа байгуулагдана.	Газар тариалан эрхлэхэд тохиромж муу хээрийн хөрстэй.
6	ҮТП-д шинжлэх ухаан, бизнесийн инкубатор байгуулах боломжтой.		6	Эрчим хүчний их үүсвэрээр тасралтгүй хангагдсан.	Бүс нутагт түүхий эдийн үнэ тогтворгүй.
7	Төрөөс үйлдвэржилтийн бодлогын баримт бичигт гадаад хамтын ажиллагаа, инноваци, шинэ технологийн зэрэг үндсэн асуудлуудыг тусгасан нь стратеги төлөвлөгөөний агуулгатай уялдаж байна.		7	Дулаанаар хангах бүрэн хүчин чадалтай.	Уурхайгаас үүдэлтэй орчны бохирдол үүсдэг.
8	Төрөөс үйлдвэржилтийн бодлогод хөрөнгө оруулалтын чиглэлээр олон улсын санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах талаар заасан		8	Нүүрс болон түгээмэл тархацтай ашигт малтмал, түүхий эдийн нөөц сайн.	
9	Мөн баримт бичигт салбарын хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангаж, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх;		9	Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийг холбосон суурин байршилтай.	
10	Байгаль орчинд халгүй технологийг төрөөс бодлогоор дэмжиж байна		10	Газар зүйн байршлын хувьд эдийн засгийн өндөр ач холбогдолтой.	
11	Холимог		11	Хөрөнгө	


	<p>үйлдвэрлэлийн парк байгуулах боломжтой,</p>		<p>оруулагчдын хувьд:          -Экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.          -Үндсэн хөрөнгийн татвар, ААН-ын орлогын албан татвар, газрын татвараас тус тус чөлөөлөх боломжтой.</p>	
12		.	12	<p>ҮТП-н эрх зүйн тухай хуулийн орчинтой. Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуультай.</p>

## ДӨРӨВ. УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ СОНГОЛТ, БОЛОМЖИТ ХУВИЛБАР

“БҮТП” ОНӨТҮГ-ын макро, микро орчны хувьд боломж, аюул бэрхшээл, дотоод орчны давуу тал, сул талыг тодорхойлсон болно. Хамт олны уулзалт хэлэлцүүлэг, чадамжийн болон стратегийн бэлэн байдлын зэрэг судалгааны үр дүнд гол хүчин зүйлсийг тодорхойлсон.

Эдгээр хүчин зүйл тус бүр дээр мэргэшсэн мэргэжилтнүүдийн оролцоотой шинжилгээ хийж үзэхэд 11 боломж, 4 бэрхшээл, 12 давуу тал, 7 сул тал тодорхойлогдсон байна. Тус нөхцөл байдлаас үзэхэд **“ТОГТВОРЖИЛТЫН СТРАТЕГИ”**-ийг 2017-2020 онд хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Зураг 8. “БҮТП” ОНӨТҮГ-ын стратегийн томъёолол



“БҮТП” ОНӨТҮГ-ын хувьд хэдийгээр боломж давамгайлж буй хэдий ч бэрхшээл, сул талууд байгаа нь шинжилгээний дүнгээс илэрхий байна. Тиймээс зах зээлд байр сууриа тогтвортой хадгалахын тулд сул талаа арилгаж, бэрхшээлийг даван туулах замаар үйл ажиллагаа явуулах стратегийн томъёолол тодорхойлогдлоо.

2020 оноос хойш хэрэгжих стратегийн ерөнхий хандлага нь өрсөлдөх чадвараа дээшлүүлэхийн тулд өөрийн давуу талуудаа бэхжүүлэхэд оршино.

## ТАВ. ГОЛ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ

А.Х.Мексоны “5Х5” шинжилгээний арга нь байгууллагад шууд болон дам байдлаар нөлөөлөх орчны хүчин зүйлсийг тодорхойлж, боломжуудыг ашиглан эрсдлээс зайлсхийх арга замыг тодорхойлдог. Тус аргачлалаар хийсэн шинжилгээний үр дүнд тулгуурлаж хөгжлийн зорилго, зорилтуудыг тодорхойлсон бөгөөд хамгийн чухал хүчин зүйлсүүдийн хүрээнд 2017-2025 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөний эрхэм зорилгыг тодорхойлсон болно. Хамгийн чухал хүчин зүйлсийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

*Мексоны асуулт 1. “БҮТП” ОНӨТҮГ-д хамгийн их нөлөөлөх гадаад орчны боломж юу вэ?*

1. Багануур үйлдвэр технологийн паркийн үйл ажиллагаа явуулахаар олгогдсон газар нь дэд бүтэц, эрчим хүчний байгууламжуудтай ойр, оновчтой байрласан.
2. Засгийн газраас үйлвэр, технологийн паркийг иж бүрдлээр хөгжүүлэх хөтөлбөр төслүүдийг дэмжих хууль эрх зүйн таатай нөхцөл бүрдэж байна.
3. БНХАУ-ын шууд хөрөнгө оруулалтаар 700 мегаваттын хүчин чадалтай эрчим хүчний шинэ эх үүсвэр ашиглалтанд орно.
4. 2018 онд Олон улсын хөрөнгө оруулалттай 2 төсөл хэрэгжих эхний бэлтгэл ажил хангагдсан.
5. УУХҮЯ, БХБЯ болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох мэргэжлийн газар, хэлтэс, албадын оролцоотойгоор зохих дүрэм, журмуудад Багануур үйлдвэр технологийн паркийн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлийг нарийн зааж өгсөн.

*Мексоны асуулт 2. “БҮТП” ОНӨТҮГ-д гадаад орчноос нөлөөлөх хамгийн аюултай 5 бэрхшээл юу вэ?*

1. Хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөөний дагуу төсвийн хөрөнгө оруулалтаар хийх инженерийн байгууламж, дэд бүтцийн ажил цаг хугацаандаа санхүүжилт авч, хийгдэхгүй байх бэрхшээл учирч болзошгүй.
2. Гадны хөрөнгө оруулагчид гэрээнд тусгагдсан төлөвлөгөөт ажлуудаа цаг хугацаандаа эхэлж чадахгүй болох .
3. Газар зохион байгуулалттай холбоотой асуудлаар Нийслэл ба Оюуны өмч, улсын бүртгэлийн еранхий газруудын хооронд үл ойлголцол гарч болох.
4. Үйлдвэр технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга эцсийн байдлаар УИХ-аар хэлэлцэгдэж батлагдаагүй.
5. Багануур ҮТП-ийн эрх зүйн байдлын статус нэг мөр тодорхой болоогүй

*Мексоны асуулт 3. “БҮТП” ОНӨТҮГ-ийн дотоод орчны хамгийн давуу 5 хүчин зүйлс юу вэ?*

1. Бүтэц орон тоо батлагдаж, төсвөөс санхүүждэг.
2. “БҮТП” ОНӨТҮГ-д бүртгэл санхүүгийн олон улсын стандарт нэвтэрсэн.
3. Санхүүгийн өргүй
4. Олон улсын төслүүдтэй хамтран ажиллаж зохих туршлага бий болсон.
5. Чанарын нэгдсэн удирдлагыг нэвтрүүлж байгаа.

*Мексоны асуулт 4. “БҮТП” ОНӨТҮГ-ийн дотоод орчны хамгийн сул 5 хүчин зүйлс юу вэ?*

1. Үйл ажиллагаа явуулах захиргааны байр байхгүй, түрээсэлж байгаа.
2. Төсвийн санхүүжилтэнд байх ёстой урсгал зардлууд тусгагдаагүй.
3. Ажиллах нөхцөл, цалин хөлснөөс шалтгаалж мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдаагүй.
4. Үйлдвэр технологийн парк хүчин чадлаараа ажиллаж эхлэхэд шаардагдах нарийн мэргэжлийн хяналт, стандарчлал, лабораторийн тоног төхөөрөмж дутагдалтай.
5. Хөрөнгө оруулалт удаашрах магадлалтай.

## ЗУРГАА. “CROSS SWOT” ШИНЖИЛГЭЭ<sup>1</sup>

Хүснэгт 9.		ГАДААД ОРЧИН	
		БОЛОМЖ /О/	АЮУЛ /Т/
<p>CROSS SWOT ШИНЖИЛГЭЭГЭЭР БОЛОМЖ, БЭРХШЭЭЛ, ДАВУУ СУЛ ТАЛУУДЫГ АЧ ХОЛБОГДЛООР НЬ ЭРЭМБЭЛЖ ХООРОНД НЬ ХАРЬЦУУЛАХ ЗАМААР СТРАТЕГИЙН ШИЙДЛҮҮДИЙГ ТОДОРХОЙЛСОН БОЛНО.</p>		<ol style="list-style-type: none"> <li>1. Багануур үйлдвэр технологийн паркийн үйл ажиллагаа явуулахаар олгогдсон газар нь дэд бүтэц, эрчим хүчний байгууламжуудтай ойр, оновчтой байрласан.</li> <li>2. Засгийн газраас үйлвэр, технологийн паркийг иж бүрдлээр хөгжүүлэх хөтөлбөр төслүүдийг дэмжих хууль эрх зүйн таатай нөхцөл бүрдэж байна.</li> <li>3. БНХАУ-ын шууд хөрөнгө оруулалтаар 700 мегаваттын хүчин чадалтай эрчим хүчний шинэ эх үүсвэр ашиглалтанд орно.</li> <li>4. 2018 онд Олон улсын хөрөнгө оруулалттай 2 төсөл хэрэгжих эхний бэлтгэл ажил хангагдсан.</li> <li>5. УУХҮЯ, БХБЯ болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох мэргэжлийн газар, хэлтэс, албадын оролцоотойгоор зохих дүрэм, журмуудад Багануур үйлдвэр технологийн паркийн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэлийг нарийн зааж өгсөн.</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>1. Хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөөний дагуу төсвийн хөрөнгө оруулалтаар хийх инженерийн байгууламж, дэд бүтцийн ажил цаг хугацаандаа санхүүжилт авч, хийгдэхгүй байх бэрхшээл учирч болзошгүй.</li> <li>2. Гадны хөрөнгө оруулагчид гэрээнд тусгагдсан төлөвлөгөөт ажлуудаа цаг хугацаандаа эхэлж чадахгүй болох.</li> <li>3. Газар зохион байгуулалттай холбоотой асуудлаар Нийслэл ба Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газруудын хооронд үл ойлголцол гарч болох</li> <li>4. Үйлдвэр технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга эцсийн байдлаар УИХ-аар хэлэлцэгдэж батлагдаагүй.</li> <li>5. Багануур ҮТП-ийн эрх зүйн байдлын статус нэг мөр тодорхой болоогүй</li> </ol>
	<b>ДАВУУ ТАЛ /S/</b>	<b>“SO” богино хугацааны зорилтууд /Хэрхэн өөрсдийн ДАВУУ ТАЛаа ашиглан БОЛОМЖ-оо нэмэгдүүлэх стратеги/</b>	<b>“ST” дунд хугацааны зорилтууд /Хэрхэн өөрсдийн ДАВУУ ТАЛаа ашиглах АЮУЛ-аа бууруулах стратеги/</b>
<b>ДОТООД ОРЧИН</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Бүтэц орон тоо батлагдаж, төсвөөс санхүүждэг.</li> <li>2. “БҮТП” ОНӨТҮГ-д бүртгэл санхүүгийн олон улсын стандарт нэвтэрсэн.</li> <li>3. Санхүүгийн өргүй</li> <li>4. Олон улсын төслүүдтэй хамтран ажиллаж зохих туршлага бий болсон.</li> <li>5. Чанарын нэгдсэн</li> </ol>		

<sup>1</sup>CROSS SWOT шинжилгээгээр “БҮТП” ОНӨТҮГ-ын хамгийн гол гадаад дотоод орчны хүчин зүйлсэд шинжилгээ хийсний үндсэн дээр гол зорилтот ажлуудыг тодорхойлсон. Эдгээр зорилтот ажлууд нь стратеги төлөвлөгөөний хувьд хөгжлийн зорилтуудаар тодорхойлогддог.

<p>удирдлагыг нэвтрүүлж байгаа.</p>		
<p><b>СУЛ ТАЛ /W/</b></p>	<p><b>“WO ” дунд хугацааны зорилтууд/Хэрхэн өөрсдийн СУЛ ТАЛаа сайжруулан БОЛОМЖ-оо нэмэгдүүлэх стратеги/</b></p>	<p><b>“WT” урт хугацааны зорилтууд /Хэрхэн өөрсдийн СУЛ ТАЛаа хамгийн бага түвшинд байлган АЮУЛ-аас хамгаалах стратеги/</b></p>
<p>1. Үйл ажиллагаа явуулах захиргааны байр байхгүй, түрээсэлж байгаа.</p> <p>2. Төсвийн санхүүжилтэнд байх ёстой урсгал зардлууд тусгагдаагүй.</p> <p>3. Ажиллах нөхцөл, цалин хөлснөөс шалтгаалж мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдаагүй.</p> <p>4. Үйлдвэр технологийн парк хүчин чадлаараа ажиллаж эхлэхэд шаардагдах нарийн мэргэжлийн хяналт, стандарчлал, лабораторийн тоног төхөөрөмж дутагдалтай.</p> <p>5. Хөрөнгө оруулалт удаашрах магадлалтай.</p>		

**ДОЛОО. “БҮТП” ОНӨТҮГ-ЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН АЛСЫН ХАРАА,  
ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛС**

---

**АЛСЫН ХАРАА**

---

Олон улсын жишигт нийцсэн эко үйлдвэрлэлийн парк болно.

---

**ЭРХЭМ ЗОРИЛГО**

---

Эрчимтэй хөгжлийн шинэчлэл нь  
үйлдвэрлэл технологийн парк байна.

---

**СУУРЬ ҮНЭТ ЗҮЙЛС**

- 
- Чадварлаг, эвсэг менежментийн баг
  - Найдвартай дэд бүтэц
  - Үйлдвэрлэлийн бодит хөрөнгө оруулалт
  - Итгэлтэй түншлэл



## НАЙМ. ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ХӨГЖЛИЙН ҮНДСЭН ЗОРИЛГУУД

### Хөгжлийн зорилго 1

Паркийн удирдлага, зохион байгуулалтанд орчин үеийн менежментийн арга барилыг тууштай нэвтрүүлнэ.

### Хөгжлийн зорилго 2

Байгаль орчинд халгүй, хаягдалгүй, дэвшилтэд технологи бүхий, экспортын чиг баримжаатай, импортын бүтээгдэхүүнийг орлох үйлдвэрлэлийн төсөл, хөтөлбөрүүдийг дэмжин хэрэгжүүлнэ.

### Хөгжлийн зорилго 3

Паркийн төсөвт зардлыг хэмнэх, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх санхүүгийн удирдлагыг нэвтрүүлэх замаар паркийн бие даасан байдлыг хангах урт хугацааны бодлогыг баримтлана.

### Хөгжлийн зорилго 4

Бүс, орон нутгийн үйлдвэржилтийг дэмжиж, нийгэм, эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд оролцоно.

### Хөгжлийн зорилго 5

Эрдэм шинжилгээ, шинэ бүтээлийн судалгаа, туршилтыг явуулах, инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.

### Хөгжлийн зорилго 6

Био эдийн засгийн салбарыг тэргүүлэн хөгжүүлнэ.

### Хөгжлийн зорилго 7

Жижиг, дунд үйлдвэр, өрхийн үйлдвэрлэл хөгжих орчныг бүрдүүлнэ.

### Хөгжлийн зорилго 8

Паркийн нийгмийн хариуцлагын бодлогыг тууштай хэрэгжүүлнэ.

## ЕС. ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ, ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД

### Зорилго 1: Удирдлага, зохион байгуулалтын хөгжлийн зорилго

Паркийн удирдлага, зохион байгуулалтанд орчин үеийн менежментийн арга барилыг тууштай нэвтрүүлнэ.

*Зорилтууд:*

- 1.1 Паркийн удирдлага, засаглалыг төлөвшүүлнэ
- 1.2 Паркийн хөгжлийг хангахуйц хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлнэ
- 1.3 Харилцаа, хамтын ажиллагааны удирдлагыг хөгжүүлнэ
- 1.4 Паркийн нэгж үйлдвэрүүдэд чанарын нэгдсэн удирдлагын системийг нэвтрүүлэх бодлогыг баримтлана.
- 1.5 Төслийн иж бүрэн удирдлагын стандартыг нэвтрүүлнэ
- 1.6 Эрсдлийн удирдлагыг цогцоор хэрэгжүүлнэ
- 1.7 Удирдлага, хяналт мэдээллийн боловсронгуй систем бүхий хөтөлбөрийг хэрэгжүүлнэ

## **Зорилго 2: Паркийн үйлдвэрлэл, үйл ажиллагаа, технологийн хөгжлийн зорилго**

Байгаль орчинд халгүй, хаягдалгүй, дэвшилтэд технологи бүхий, экспортын чиг баримжаатай, импортын бүтээгдэхүүнийг орлох үйлдвэрлэлийн төсөл, хөтөлбөрүүдийг дэмжин хэрэгжүүлнэ.

*Зорилтууд:*

- 2.1. Өндөр технологид суурилсан экспортыг орлох бүтээгдэхүүнүйлдвэрлэлийгдэмжинэ.
- 2.2. Өндөр технологид суурилсан импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийгдэмжинэ.
- 2.3. Зүүн бүс ба орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжихэд паркийн үйл ажиллагааг чиглүүлнэ.
- 2.4. Байгаль орчинд халгүй, хаягдалгүй, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг голлон дэмжинэ.
- 2.5. Дэд бүтэц, эрчим хүчний байгууламжийн асуудлыг байгаль орчинд хор хөнөөлгүй технологид суурилан шийдвэрлэнэ.

## **Зорилго 3: Санхүүгийн хөгжлийн зорилго**

Паркийн төсөвт зардлыг хэмнэх, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх санхүүгийн удирдлагыг нэвтрүүлэх замаар паркийн бие даасан байдлыг хангах урт хугацааны бодлогыг баримтлана.

*Зорилтууд:*

- 3.1. Хөрөнгө оруулалтын менежментийнбодлогыг сайжруулах замаар паркад үйлдвэрүүдийг байгуулах арга хэмжээ авна.Мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.
- 3.2. Паркийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээг байгуулах санхүүжилтийг шийдвэрлэнэ.

- 3.3. Паркийн нэгжийн үйлдвэрүүдийн үйл ажиллагааг үр ашигтай явуулах тогтвортой бодлогыг хэрэгжүүлнэ.
- 3.4. Санхүүгийн төлөвлөгөө тайлагнал хяналтыг сайжруулж, санхүүгийн чадавхийг нэмэгдүүлнэ.
- 3.5. Хэмнэлтийн бодлого хэрэгжүүлнэ.
- 3.6. Паркийн үйл ажиллагааг өргөтгөх замаар санхүүгийн бие даасан байдлыг хангах урт хугацааны бодлогыг баримтлана.

#### **Зорилго 4: Нийгэм эдийн засгийн хөгжлийн зорилго**

Бүс, орон нутгийн үйлдвэржилтийг дэмжиж, нийгэм, эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд оролцоно.

Зорилтууд:

- 4.1. Хамт олны нийгмийн хэрэгцээ шаардлагыг нарийвчлан тогтоож хөгжлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

#### **Зорилго 5: Шинжлэх ухаан, инноваци**

Эрдэм шинжилгээ, шинэ бүтээлийн судалгаа, туршилтыг явуулж инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

Зорилтууд:

- 5.1. Шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр эрдэм шинжилгээ туршилт судалгааны ажлыг зохион байгуулж инновацийн төслүүдийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.
- 5.2. Орчин үеийн дэвшилтэт техник технологи, шинжлэх ухааны мэдээллийн судалгаа явуулж үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжуудыг тодорхойлно.

#### **Зорилго 6: Биотехнологийн хөгжлийн зорилго.**

Монгол Улсын тэргүүлэн хөгжүүлэх биотехнологийн салбарын бодлогыг дэмжиж паркад нанобиотехнологи болон ургамлын биотехнологийн үйлдвэрлэлийн цогцолборуудыг иж бүрдлээр байгуулах замаар “Био эдийн засгийн үйлдвэрийн загварынбааз” бий болгоно.

Зорилтууд:

- 6.1. Монгол улсад био эдийн засгийн салбарыг тэргүүлэн хөгжүүлнэ
- 6.2. Биотехнологийн шинжлэх ухааны шилдэг техник, технологиудыг нэвтрүүлнэ.
- 6.3. Биотехнологийн үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлснээр экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэж, валютын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

#### **Зорилго 7: Жижиг дунд үйлдвэрлэл**

Жижиг, дунд үйлдвэр, өрхийн үйлдвэрлэл хөгжих орчныг бүрдүүлнэ.

Зорилтууд:

- 7.1. Жижиг, дунд болон өрхийн үйлдвэрүүдийг дэвшилтэт техник технологийн мэдээллээр хангана.
- 7.2. Жижиг, дунд болон өрхийн үйлдвэрүүдийг кластерийн нэгдсэн системд хамруулж, хөгжих боломжийг бүрдүүлнэ.

### **Зорилго 8 : Нийгмийн хариуцлагын хөгжлийн бодлого**

Паркийн нийгмийн хариуцлагын бодлогыг тууштай хэрэгжүүлнэ.

- 8.1. Паркийн нийгмийн хариуцлагын хөтөлбөр боловсруулна.
- 8.2. Парк, түүний нэгж үйлдвэрүүдэд ХАБЭА-н удирдлагын систем нэвтрүүлнэ.
- 8.3. Хамт олны нийгмийн хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.

**АРАВ. СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

№	ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	Тэнцвэржүүлсэн үнэлгээ				ХАРИУЦАХ АЛБАН ТУШААЛТАН	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХҮРЭХ ҮР ДҮН	ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА	САНХҮҮЖИЛТ /сая төг/
		ХҮНИЙ НӨӨЦ	ҮЙЛДВЭРЛЭЛ	ХЭРЭГЛЭГЧ	САНХҮҮ					
<b>1.</b>	<b>Стратегийн үйл ажиллагааны зорилго 1: УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО</b>									
<b>1.1</b>	<b>1.1. Стратегийн үйл ажиллагааны зорилт: Паркийн удирдлага, засаглалыг төлөвшүүлнэ</b>					<b>Хүрэх үр дүн: Удирдлагын үйл ажиллагаа сайжирч, бүтээмж дээшилнэ.</b>				
<b>1.1.1</b>	Паркийн ТУЗ байгуулах асуудлыг судлаж шийдвэрлүүлнэ. / НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015.07.03-ны өдрийн 122-р тогтоолын хавсралт/	+				Удирдлага	ТУЗ байгуулах судалгаа гарна	Удирдах дээд байгууллагаас санал авна	2018	-
<b>1.1.2</b>	ҮТПаркийн засаглалыг сайжруулах чиглэлээр судалгаа хийж, авах арга хэмжээний талаар санал боловсруулах.	+				Удирдлага, хүний нөөцийн ажилтан	Засаглалыг сайжруулах судалгаа	Засаглалыг сайжруулах санал боловсруулагдана	2018-2019	-
<b>1.1.3</b>	Стратегийн удирдагчийн (манлайлагчийн) тодорхойлт гаргах.	+				Хүний нөөц	Манлайлагчийн тодорхойлт	Удирдагч өөрийгөө боловсруулна	2017	-
<b>1.1.4</b>	Орчин үеийн менежментийн шинэ хандлагийн дагуу Парк-Суралцагч байгууллага байх нөхцөлийг бүрдүүлж нийт ажилтнуудын өөрсдөө сурах, хөгжин боловсрох боломжуудийг бүрдүүлэх замаар паркийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцуулах арга хэмжээ	+		+		Хүний нөөц Удирдлага	“Суралцагч байх” тодорхойлолтыг гаргасан байна.	Суралцах сэдвийн төлөвлөгөөтэй ажиллана.	Жил бүр	-

	зохион байгуулах										
1.1.5	Паркад кластерийн удирдлагыг нэвтрүүлэх загварыг боловсруулж, хэрэгжүүлэх арга замуудыг судлах	+		+		Удирдлага, паркийн мэргэжилтэн	Кластерийн удирдлагын загвар	Кластерийг хэрэгжүүлэх арга зам боловсруулагдана	2017-2018	-	
1.1.6	“Багануур Үйлдвэрлэл, Технологийн Парк”-ийн мэдээллийн бодлого /PR/боловсруулж хэрэгжүүлэх	+				Сургалт сурталчилгаа	Гадаад, Дотоод мэдээллийг түгээх арга техник боловсруулах, сургах, PR-ийн бодлогыг сайжруулах	Мэдлээлийн зөв тогтолцоо бүрдсэн байна	Жил бүр	10,0	
1.1.7	Технологид суурилсан ажлын байрыг бүрдүүлж ажилтнуудыг мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах.	+			+	Удирдлага Санхүү	Технологид суурилсан ажлын байрны тодорхойлолт гарсан байна.	Ажлын байрны техник хангамж шинэчлэгдсэн байна.	2018-2020	18,0	
1.1.8	Байгууллагын архив, бичиг баримтыг стандартын дагуу хөтлөх		+	+		Архив, бичиг хэрэг	Архив, бичиг хэргийн стандарт	Стандартын дагуу архивын сан бүрдсэн байна	2017 оноос	5,0	
1.2.	<b>Стратегийн үйл ажиллагааны зорилт:</b> Паркийн хөгжлийг хангахуйц хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлнэ						<b>Хүрэх үр дүн:</b> Хүний нөөцийн тасралтгүй хэрэгцээг хангах, хүний нөөцийн менежментийг сайжруулна				
1.2.1	Хүний нөөцийн тасралтгүй хэрэгцээг хангах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. • Хүний нөөцийн менежмент • Хүний нөөцийн удирдлагын шинэчлэл	+	+			Удирдлагын баг, холбогдох мэргэжилтнүүд	Хүний нөөцийн менежмент бодлого боловсруулагдана	Менежментийн бодлого хэрэгжиж, хүний нөөцийн удирдлагын шинэчлэгдэнэ	2017-2020	-	
	Өнөөгийн нөхцөлд тохируулж паркийн удирдлага зохион байгуулалтын бүтцийг шинэчлэх. Үүнд:	+				Удирдлагын баг	Хэлэлцүүлгийн тоо, Хэлэлцүүлэгт хамрагдсан гишүүдийн тоо	Засаглалын талаар нэгдсэн ойлголт бий болно	2017		
	• Бүтэц орон тоонд судалгаа хийх	+				Хүний нөөцийн ажилтан	Судалгаа хийгдэнэ	Бүтэц орон тооны загвар	2017-2018	-	

	<ul style="list-style-type: none"> <li>Орон тоо төсвийг шинэ бүтцээр батлуулж мөрдөх</li> </ul>	+			+	Хүний нөөц, Санхүү	Шинэ бүтэц	Орон тоо төсвийг НЗД-аар батлуулсан байна	2017 жил бүр	-
	<ul style="list-style-type: none"> <li>Паркийн удирдлагын мэргэжлийн менежментийн баг бүрдүүлэх</li> </ul>	+				Хүний нөөц	Орон тоо	Менежментийн баг	2017-2018	-
	<ul style="list-style-type: none"> <li>Паркийн ажилтнуудын шалгуур үзүүлэлтийг баталгаажуулж мөрдөх</li> </ul>	+				Удирдлага, Хүний нөөц	Шалгуур үзүүлэлт	Даргаар батлагдсан байна	2017	-
	<ul style="list-style-type: none"> <li>Паркад сонгон шалгаруулалтаар ажилд авах журам тогтоох</li> </ul>	+				Хүний нөөц	СШ журам	Журмыг мөрдөж ажиллана.	2017	-
1.2.2	Ажилтнуудын ажлын ачааллын зураг авалт зохион байгуулах.	+				Хүний нөөц	Ажилтнууд хронометражид бүрэн хамрагдана	Ажилтнуудын ажил үүрэг, ачааллыг тэнцвэржүүлэх боломтой болно.	2018	-
1.2.3	<p>Паркийн нийт ажилтан нараас мэргэжлийн чиглэлээр аттестатчлалын шалгалт тогтмол авах. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>Мэргэжил</li> <li>Техник технологийн мэдлэгийн түвшин</li> <li>Хуулийн мэдлэг</li> <li>Гадаад хэлний мэдлэг</li> <li>Монгол хэлний мэдлэг</li> </ul>	+			+	Удирдлага, Хүний нөөц	Аттестатчлалын хөтөлбөр	Ажилтнуудын мэдлэгийн түвшин дээшлэнэ	Жил бүр	2,4
1.2.4	<p>Паркийн ажилтнуудын мэргэжлийн түвшинг дээшлүүлэх сургалтыг төлөвлөгөөтэйгөөр дараах чиглэлээр зохион байгуулах</p> <ul style="list-style-type: none"> <li>Стратеги удирдлага</li> <li>Менежмент</li> <li>Маркетинг</li> <li>Төсөл, ТЭЗҮ боловсруулах</li> </ul>	+			+	Удирдлага Хүний нөөц	Сургалтын төлөвлөгөө	Мэргэжлийн багш эрдэмтдээр сургалтыг зохион байгуулна.	2018-2020	3,5

	<ul style="list-style-type: none"> <li>• Хаягдалгүй технологи</li> <li>• Биотехнологи</li> <li>• Нанобиохими</li> </ul>										
1.2.5	Менежментийн чадамжийг судлах дээшлүүлэх сургалтын арга хэмжээ	+				Удирдлага, Хүний нөөц	Менежментийн чадамжийн 9 үзүүлэлтийн өссөн хувь, тоо хэмжээ, тайлан	Хамт олны менежментийн чадамж дээшилсэн байна.	2017-2020	4,0	
1.2.6	Гүйцэтгэлийн үнэлгээг боловсронгуй болгох замаар цалин урамшууллын оновчтой тогтолцоог бий болгоно.	+			+	Удирдлага, хүний нөөц, санхүү	Гүйцэтгэлийн үнэлгээг шинэчлэн боловсруулна.	Цалин урамшууллын журам хэрэгжинэ.	2017-2020	-	
1.2.7	Паркийн нэгж үйлдвэрүүдийн хүний нөөцийн бүрдүүлэлт, ажилтнуудын сургалтанд дэмжлэг үзүүлэх.		+	+		Хүний нөөц, сургалт, сурталчилгаа	Ажил горлигчдын судалгаатай байх	Үйлдвэр аж ахуй газруудыг МСҮТөвүүдтэй холбоно.	2018	-	
1.3	<b>Стратегийн үйл ажиллагааны зорилт:</b> Харилцаа, хамтын ажиллагааны удирдлагыг сайжруулах						<b>Хүрэх үр дүн:</b> Засгийн газар, яам, хэрэглэгч, хамтран ажиллагч зэрэг оролцогч талуудын сонирхолын цэгийг тогтоох замаар бүтээмж өснө.				
1.3.1	Олон улсын төсөл, хөтөлбөрт хамрагдах болон Засгийн газрын дэмжлэг авах боломж гарцуудыг судлах		+		+	Удирдлага, хөрөнгө оруулалтын мэргэжилтэн	Төсөлт хөтөлбөрүүдийн судалгаа гаргасан байна.	Жилд 1 ээс доошгүй төсөл хөтөлбөрт хамрагдсан байна.	Жил бүр	16,0	
1.3.2	Олон улсын хөрөнгө оруулагчдийн форумд тогтмол оролцож байх		+		+	Удирдлага	Хийгдсэн хөрөнгө оруулалтын хэмжээ	Хөрөнгө оруулагчдийн татсан байна.	Жил бүр	80,0	



1.3.3	Нэгжүүдийн үйлдвэр, тэдгээрийн бүтээгдэхүүнийг олон улсын болон дотоодын техник, технологийн үзэсгэлэн яармагт оролцуулж сурталчлах.		+		+	Удирдлага, хөрөнгө оруулалтын мэргэжилтэн, сургалт, сурталчилгааны мэргэжилтэн	Олон улсын болон дотоодын техник технологид инноваци нутагшуулна	Жилд 2-оос доошгүй удаа хамрагдсан байна.	Жил бүр	16,0
1.3.4	Гадаад дотоодын түнш харилцагчдын судалгаатай болох. • Хамтран ажиллах боломжит чиглэлүүдийг тодорхойлох. • Судалгаанд шинэчлэлийг тогтмол хийж баяжуулах.		+			Сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	Үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажиллана	Хамтын төсөл хөтөлбөрүүд хэрэгжсэн байна.	2017-2020	-
1.4	<b>Стратегийн үйл ажиллагааны зорилт:</b> Паркийн нэгж үйлдвэрүүдэд чанарын нэгдсэн удирдлагын системийг нэвтрүүлэх бодлогыг баримтлана					<b>Хүрэх үр дүн:</b> Удирдлагын тогтолцоо нэвтрүүлснээр бүтээмж өснө.				
1.4.1	ISO9001- Чанарын удирдлагын тогтолцоог нэгж үйлвэрүүдэд хэрэгжүүлэхэд мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх	+	+			Парк хариуцсан мэргэжилтэн	Дүрэм журам боловсруулж мөрдөж ажиллах	Бүтээмж нэмэгдсэн байна.	2017-2022	-
1.4.2	ХАБЭА-н удирдлагын тогтолцоог нэгж үйлвэрүүдэд нэвтрүүлэх, хэрэгжүүлэх, тасралтгүй сайжруулан хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	+				Парк хариуцсан мэргэжилтэн	Стандарт нэвтэрч мөрдөж ажиллах	Зөрчлийн тоо буурсан байна	2017-2017	-
1.4.3	Паркийн үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнүүд MNS, ISO стандартыг хангасан байх нөхцлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх		+	+		Парк хариуцсан мэргэжилтэн	MNS, ISO стандартыг баримтлана	Бүтээгдэхүүнүүд стандартын шаардлага хангана.	2019 оноос	-
1.5	<b>Стратегийн үйл ажиллагааны зорилт:</b> Төслийн иж бүрэн удирдлагын стандартыг нэвтрүүлнэ.					<b>Хүрэх үр дүн:</b> Бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ нэмэгдэж борлуулалтын орлого өснө				
1.5.1	MNS, ISO-21500 төслийн	+	+	+		Удирдлага,	Хөтөлбөр гарна	Хөтөлбөрийг	2018-	8,0

	<p>удирдлагын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх.</p> <ul style="list-style-type: none"> <li>Төслийн орчин</li> <li>Төслийн үйл явцууд ба төслийн нэгдсэн удирдлага</li> <li>Төслийн эхлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, төгсгөх үйл явцуудад:</li> <li>Төслийн оролцогч талууд</li> <li>Төслийн хамрах хүрээ</li> <li>Төслийн нөөц, цаг хугацаа</li> <li>Төслийн зардал, эрсдэл, чанарын удирдлага</li> <li>Төслийн худалдан авалт</li> <li>Төслийн харилцааг хэрхэн зөв зүйтэй, үр ашигтай удирдах бодит арга зүй</li> </ul>					ҮТАлбаны ажилтнууд		төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.	2020		
<b>1.6</b>	<b>Стратегийн үйл ажиллагааны зорилтыг</b>					<b>Хүрэх үр дүн:</b>					
	Эрсдлийн удирдлагыг цогцоор хэрэгжүүлнэ					Эрсдлийг бууруулж үйлдвэрийн найдвартай байдлыг сайжруулна.					
<b>1.6.1</b>	<p>Паркийн болон нэгжүүдийн үйл ажиллагааны эрсдлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагатай хамтран гаргах ажлыг зохион байгуулах</p>			+		Удирдлагын баг, холбогдох мэргэжилтнүүд	Эрсдлийн үнэлгээ	Баримт бичиг боловсруулагдан, эрсдэл буурна.	2018-2020	24.0	
<b>1.6.2</b>	<p>Эрсдлийн удирдлагын гадаад нөхцөл байдлыг шийдвэрлүүлэх арга хэмжээ авах. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>нийгэм, улс төр, хууль тогтоомж, зохицуулалт, технологи, эдийн засаг, соёл, байгаль орчны болон өрсөлдөөний орчин,</li> <li>байгууллагын зорилгод нөлөөлөх гол чиглэл болон хандлага,</li> </ul>			+		Удирдлагын баг, холбогдох мэргэжилтнүүд	Эрсдлийн үнэлгээ	Баримт бичгийг танилцуулж үр дүнд хүрсэн байх	2018-2020	-	

	<ul style="list-style-type: none"> <li>• гадаад харилцагчдын харилцан мэдээлэл, ойлголт болон үнэ цэнэ</li> </ul>									
1.6.3	<p>Эрсдлийн удирдлагын дотоод нөхцөл байдлыг шийдвэрлүүлэх. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• засаглал, зохион байгуулалтын тогтолцоо,</li> <li>• зорилт, түүнд хүрэх стратеги,</li> <li>• нөөц болон мэдлэгийн (хөрөнгө, хугацаа, хүмүүс, үйл явц, тогтолцоо ба технологи) чадамж</li> <li>• мэдээллийн урсгал ба шийдвэр гаргах үйл явц,</li> <li>• дотоодын харилцагчид,</li> <li>• ойлгоц, үнэ цэнэ; байгууллагын соёл,</li> <li>• байгууллагын баталсан стандарт, арга зүйн заавар болон загвар,</li> <li>• гэрээт хамтын ажиллагааны хэлбэр, цар хүрээ,</li> </ul>			+	Удирдлагын баг, холбогдох мэргэжилтнүүд	Эрсдлийн үнэлгээ	Баримт бичгийг танилцуулж үр дүнд хүрсэн байх	2018-2020	9,0	
1.7	<p><b>Стратегийн үйл ажиллагааны зорилт:</b> Удирдлага, хяналт мэдээллийн боловсронгуй систем бүхий хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.</p>					<p><b>Хүрэх үр дүн:</b> Удирдлага, хяналт мэдээллийн системийг бүрэн автомат ухаалаг сүлжээ нэвтрэнэ.</p>				
1.7.1	<p>Удирдлага мэдээллийн сүлжээний найдвартай ажиллагаа харилцан адилгүй бүх шатанд сайжруулах</p> <ul style="list-style-type: none"> <li>• интернет холболтын хурд шаардлага хангахгүй,</li> </ul>			+	+	Удирдлагын баг, холбогдох мэргэжилтнүүд	Хөтөлбөрийн үнэлгээ	Үе шат бүрийн зорилтыг хангана	2017-2020	20,0

	<ul style="list-style-type: none"> <li>мэдээллийн сүлжээний физик болон логик хамгаалалт хангалтгүй,</li> <li>цахим баримт бичиг, мэдээ мэдээллийн нөөц үүсгэх ажил хангалтгүй,</li> </ul>									
1.7.2	<p>Open ERP систем нэвтрүүлэх</p> <ul style="list-style-type: none"> <li>агуулах, хангамж, борлуулалт, үйлдвэрлэлт, санхүү модулиуд бизнес үйл ажиллагааг цахим хэлбэрт загварчилж, боловсруулалт,автоматжуулалт хийх</li> </ul>		+		+	Удирдлагын баг, холбогдох мэргэжилтнүүд	Системийг хэрэглэх нэгж хэсгийн тоо	ERP систем бүрэн нэвтэрсэн байна.	2018	6,0
№	ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	Тэнцвэржүүлсэн үнэлгээ				ХАРИУЦАХ АЛБАН ТУШААЛТАН	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХҮРЭХ ҮР ДҮН	ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА	САНХҮҮЖИЛТ /сая төг/
		ХҮНИЙ НӨӨЦ	ҮЙЛДВЭРЛЭЛ	ХЭРЭГЛЭГЧ	САНХҮҮ					
2.	Стратегийн үйл ажиллагааны зорилго 2: ПАРКИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТЕХНОЛОГИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО									
2.1	Стратегийн үйл ажиллагааны зорилт: Өндөр технологид суурилсан экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.						Хүрэх үр дүн: Өндөр технологид суурилсан экспортын бүтээгдэхүүний үйлдвэрүүд байгуулагдах			
2.1.1	<p>Экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дараах үйлдвэрүүдийг байгуулж хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжинэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>“Адуу брэнд”-ийн эмийн болон гоо сайхны цуврал бүтээгдэхүүний үйлдвэрлэл</li> <li>Ноос гүн боловсруулах “Силкроуд Аёри Монгол” ХХК-ны онгоцны дулаалгын</li> </ul>		+			Үйлдвэрлэл технологийн албаны ажилтнууд	Шинэ цуврал бүтээгдэхүүн  Үйлдвэрийн төсөл, ТЭЗҮ боловсруулагдана	Адуу брэндийн үйлдвэрлэл өргөжинө.  Үйлдвэр баригдана.	2017 оноос	-
			+	+	+				2018 оноос	-

	<ul style="list-style-type: none"> <li>материалын үйлдвэр</li> <li>Ховор, ховордсон эмийн ургамалыг тарималжуулах биотехнологийн плантацийг хөгжүүлж, дагалдах эмийн болон гоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэрүүд</li> <li>Гар хивсний урлалын туршилтын үйлдвэр</li> </ul>			+			Плантацийн төсөл, ТЭЗҮ боловсруулагдана	Тарималжуулалтын байгууламжууд баригдсан байна.	2018 оноос	150.0
				+	+		Гар урлалын суралцагчид бэлтгэгдэнэ	Үйлдвэр цех ажилд орно.	2018 оноос	180.0
<b>2.2</b>	Импортыг орлох бүтээгдэхүүний дараах үйлдвэрүүдийг байгуулж хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжинэ. Үүнд:									
	<ul style="list-style-type: none"> <li>“Монгол шингэн нүүрс” ХХК-ийн нүүрснээс шингэн түлш гарган авах үйлдвэр</li> </ul>		+	+		Үйлдвэрлэл технологийн албаны ажилтнууд	Анхны модуль ашиглалтад орно	Хүчин чадлын өргөтгөл барьж эхлэхэд бэлэн болно.	2018-2020	-
	<ul style="list-style-type: none"> <li>Нүүрснээс гаралтай эрдэс бордооны үйлдвэр</li> </ul>		+	+	+	Үйлдвэрлэл технологийн албаны ажилтнууд	Эрдэс бордооны технологийг хагас үйлдвэрлэлийн туршилт дууссан байна.	Анхны үйлдвэр ашиглалтад орно	2018-2020	70.0
<b>2.2.1</b>	Уламжлалт үйлдвэрлэлд хаягдалгүй байгальд халгүй технологийг нэвтрүүлж хөгжүүлэх. Үүнд:									
